

Элч Нарын Тунхаг

2-р хичээл

Бурхан Эцэг

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

© 2014 Гурав Дахь Мянган Үйлчлэл

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Библийн бүх эшлэлийг Ариун Библи 2019 (АБ2019), Ариун Бичээс Нийгэмлэг.

ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ

Гурав дахь мянган үйлчлэл нь 1997 онд үүсгэн байгуулагдсан, ашгийн бус, Христитгэлийн Сайнмэдээний үйлчлэл бөгөөд дараах талбаруудад чиглэдэг:

Библийн Боловсролыг. Бүх дэлхийд. Үнэгүйгээр.

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, дахин давтагдашгүй, цуврал хичээлүүдийг Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчлэлүүдээр маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг. Эдгээр нь сургууль, бүлгүүд, хувь хүмүүс танхимаар болон цахимаар ашиглахад зориулагдсан болно.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловсруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид нь теологийн мэргэжлийн сургагч багш нар, орон орны орчуулагч нар маань теологийн мэдлэгтэй зэрэг давуу талтай юм. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд Гурав дахь мянган үйлчлэл нь сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.thirdmill.org цахим хуудсаар зочлоорой.

Элч нарын тунхаг

2-р хичээл

Бурхан Эцэг

Гарчиг

УДИРТГАЛ	1
БУРХАН	2
Цорын ганц чанар	3
Политейзм.....	3
Монотейзм	5
Христитгэл.....	7
Нэгдмэл чанар	9
ТӨГС ХҮЧИТ ЭЦЭГ БУРХАН	11
Нэр.....	11
Бодгаль.....	13
Эцэгийн үүрэг	16
Бүтээгч	16
Хаан	17
Өрхийн тэргүүн.....	19
Хүч чадал.....	21
Хязгааргүй	21
Зүйрлэшгүй.....	24
БҮТЭЭГЧ	25
Бүтээлийн үйлс.....	25
Бүтээлийн сайн сайхан	28
Бүтээлийн дээрх эрх мэдэл	30
Бүрэн эрхт эрх мэдэл	30
Хосгүй онцгой эрх мэдэл	32
Бүхнийг хамарсан эрх мэдэл.....	32
ДҮГНЭЛТ	33
ХАМТРАГЧИД	34
ҮГСИЙН ТАЙЛБАР	36

Элч нарын тунхаг

Хоёрдугаар хичээл

Бурхан Эцэг

УДИРТГАЛ

Олон шашин “Бурхан” гэж нэрлэх ямар нэгэн оршихуйг шүтдэг. Үүнээс үүдэн сонирхолтой асуултууд урган гардаг. Энэ бүх шашин нэг л бурхныг өөр өөрөөр нэрлэн шүтдэг юм болов уу? Эсвэл бүгд л өөр өөр бурхныг шүтдэг үү? Тэгвэл хэдий олон янзын шашнууд “Бурхан” гэдэг нэг л ижил үгийг ашигладаг ч үүгээрээ өөр өөр зүйлсийг илэрхийлдэг гэж Библид тайлбарласан байдаг. Бичвэр нь Христитгэгчдийн Бурхан бол цорын ганц, үнэн Бурхан гэдгийг онцолдог. Тэгэхээр бусад шашны бурхад бол хуурамч шүтээн, хуурамч бурхад гэсэн үг юм. Тийм ч учраас Христитгэгчид Библийн Бурханыг таньж мэдэхийг ихэд чухалчилсаар ирсэн билээ. Тэр бол цорын ганц, үнэн Бурхан мөн. Түүнд л бүхнийг бүтээх, устгах ба аврах хүч чадал бий.

Энэ бол *Элч нарын тунхаг* гэсэн цуврал хичээлийн маань хоёрдугаар хичээл юм. Энэ хичээлийн нэр бол “Бурхан Эцэг”. Бид энэ хичээлээрээ *Элч нарын тунхаг* дахь итгэлийн эхний үндсэн тунхаглал болох Гурвалын эхний бодгаль буюу Бурхан Эцэгт итгэх итгэлийн тунхаглалын тухай үзэх болно.

Өмнөх хичээлд үзсэнчлэн *Элч нарын тунхаг* нь чуулганы эхэн үед янз бүрийн хувилбараар гарч ирж байсан. Харин латин хэл дээр МЭ 700-аад оны үед стандарт хэлбэрээ олсон байдаг. Орчин цагийн Англи хэл дээрх хамгийн түгээмэл хувилбарыг харцгаая:

Би тэнгэр газрыг Бүтээгч,
Төгс хүчит Бурхан Эцэгт итгэдэг.
Ариун Сүнсээр олдож,
Онгон Мариаас мэндэлсэн,
Понти Пилатын дор зовж явсан,
Цовдлогдон нас барж, оршуулагдаад
Үхэгсдийн орон руу яваад,
Гурав дахь өдрөө үхлээс дахин амилсан,
Тэгээд мөнхийн улс руу одож,
Төгс хүчит Бурхан Эцэгийнхээ
Баруун мутарт заларсан,
Тэндээс үхсэн, амьд
Бүх хүнийг шүүхээр ирэх
Түүний цорын ганц Хүү
Бидний Эзэн Есүс Христэд би итгэдэг.
Би Ариун Сүнсэнд итгэдэг.
Ариун нэгдмэл чуулган,
Ариун хүмүүсийн нөхөрлөл,
Гэмийн уучлал,
Биений дахин амилалт болон

Мөнхийн амьдралд итгэдэг. Амен.

Эдгээр хичээлээр бид *Элч нарын тунхгийг* таван үндсэн хэсэгт хувааж үзсэн гэдгийг та санаж байгаа байх. Эхний гурван хэсэг нь Бурханы гурван бодгаль болох Эцэг, Хүү, Ариун Сүнсний тухай байдаг. Дараагийн хоёр хэсэг нь чуулганы болон авралын тухай байдаг. Энэ хичээлээр бид эдгээр таван хэсгийн хамгийн эхний хэсэг болох итгэлийн эхний үндсэн тунхаглалыг авч үзнэ:

**Би тэнгэр газрыг Бүтээгч,
Төгс хүчит Бурхан Эцэгт итгэдэг.**

Итгэлийн энэхүү үндсэн тунхаглал дахь сэдвүүдийг хувааж болох олон арга бий. Гэхдээ бид энэ хичээлээр Христитгэлийн теологийн цөм болсон гурван сэдвийг онцлон үзэх болно. Эдгээр нь Бурханы талаарх ойлголт, Төгс Хүчит Бурхан Эцэгийн бодгаль чанар ба Түүний бүх бүтээлийн Бүтээгч үүргийнх нь тухай юм.

Энэ гурван гол сэдвийн дагуу Бурхан Эцэг гэсэн энэ хичээлээ бид гурван хэсэгт хуваасан байгаа. Нэгдүгээрт, Бурханы тухай үндсэн ойлголт буюу Библид Түүний оршихуй, мөн чанарын тухай юу гэж заасныг авч үзнэ. Хоёрдугаарт, “Төгс Хүчит Бурхан Эцэг” гэсэн хэллэгийг авч үзэхдээ Гурвалын эхний бодгалийн онцлог мөн чанарт анхаарлаа хандуулна. Гуравдугаарт, Эцэгийн оршин буй бүхнийг бүтээсэн Бүтээгчийн үүрэг оролцоог судлах болно. Ингээд бүгдээрээ Библи дэх Бурханы тухай ойлголтыг эхлээд үзье.

БУРХАН

Бурханд итгэх итгэл маань бидний бусад бүх зүйлд итгэх итгэл үнэмшлийн маань суурь болдог юм шүү дээ. Тэгэхээр ертөнцийг үзэх үзлийн тухай ярих юм бол, Бурхан яг төвд нь байж, бусад бүх зүйл Түүнтэй ямар нэг байдлаар холбоотой байна гэсэн үг юм. Энэ бол манай нийгэмд байдаг хүн төвтэй, би төвтэй буюу бүх зүйлийг, тэр байтугай Бурханыг хүртэл өөртэйгөө ямар хамааралтай вэ гэдэг талаас нь үздэг нийтлэг хандлагаас бүхий л талаараа өөр буюу Бурхан төвтэй хандлага гэсэн үг юм. Би төвтэй байх нь Библийн дагуух үзэл бодлын яг эсрэг, Бичвэрийн илчилсэн Бурханы үзэл бодлын эсрэг зүйл гэж хэлэхэд ч буруудахгүй байх гэж би бодож байна. Тиймээс бид үйлчлэлдээ бидний төрөлх мөн чанар би-төвтэй байхгүйг хичээх хэрэгтэй. Харин Бурхан-төвтэй байж, би-төвтэй байхын оронд Бурхан-төвт ертөнцийг үзэх үзэлтэй байхыг хичээх хэрэгтэй.

— Др. Ж. И. Пакер

Бид Бичвэрт илчлэгдсэн Бурханы талаарх үндсэн ойлголтыг хоёр сэдвийн

хүрээнд авч үзэх болно. Эхлээд, “Бурханы цор ганц чанар” гэж теологичдын нэрлэдэг Тэр бол оршин буй цорын ганц Бурхан гэдэг ойлголтыг үзнэ. Дараа нь, Бурханы нэгдмэл чанарын тухай буюу Бурхан гурван бодгалиар оршдог ч цорын ганц Бурхан гэдэг талаар мөн ярилцах болно. Ингээд Бурханы цор ганц чанар буюу Библийн Бурхан бол цорын ганц бөгөөд үнэн Бурхан юм гэсэн онол сургаалын тухай одоо үзье.

ЦОР ГАНЦ ЧАНАР

Бурханы цор ганц чанарыг судлахдаа эхлээд бид чуулганы эхэн үед дэлхий дахинаа өргөн тархаад байсан олон бурхныг шүтэх шүтлэг буюу политеизмын тухай ярилцах болно. Хоёрдугаарт, ганц бурхныг шүтэх шүтлэг болох монотеизмын тухай судална. Гуравдугаарт, Христитгэл дэх Бурханы талаарх ойлголтыг авч үзнэ. Тэгэхээр эхлээд олон бурхдыг шүтэх тухай авч үзье.

Политеизм

Политеизм бол орчлон ертөнцийг захирдаг хүчирхэг ер бусын оршихуй болох олон бурхад байдаг гэдэгт итгэх итгэл юм. Эдгээр бурхдын заримыг нь мөнх бөгөөд бүтээгдээгүй гэж үздэг бол заримыг нь ямар нэг байдлаар төрсөн бөгөөд бүтээгдсэн гэж үздэг. Олон бурхныг шүтэх шүтлэгт бурхад бүр ихэнхдээ бие биеэсээ ялгаатай байдаг. Мөн хүн бүр онцгой байдаг шиг тэд ч бас ямар нэг зүйлээрээ онцгой байдаг гэдэг. Гэвч политеизмд орчлон ертөнцийг бүхэлд нь захирдаг, онцгой цор ганц бурхан гэж нэг ч байхгүй.

Политеизмийн нэг түгээмэл хэлбэр бол хенотеизм юм. Энэ нь ганц бурханд л итгэн, өөрийгөө зориулдаг ч бусад бурхдыг бас үгүйсгэдэггүй үзэл юм. Жишээ нь, Ромын Эзэнт Гүрний үед зарим хүмүүс Зевсийг агуу хүчит бурхан гэж өргөмжилдөг байсан ч бусад бурхдыг мөн хүлээн зөвшөөрдөг байв.

Чуулганы эхэн үеийн нийгэмд ихэнх Христитгэгч биш хүмүүс олон бурхан шүтдэг байсан. Маш олон хүмүүс Грек, Ромын хуурамч бурхдад итгэж, эртний Ойрх Дорнодын шүтээнүүдэд мөргөдөг байв. Тэр ч бүү хэл, гараг эрхсийн хүч ба бүтээлүүдэд мөргөдөг байсан аж. Харин атеизм буюу бурхангүй үзэл тун ховор байжээ.

Политеизм түгээмэл байсны нэг шалтгаан нь үүнийг хуулиар шаарддаг байсан явдал юм. Жишээ нь, Ромын Эзэнт Гүрний засгийн газар нь Ромын бурхдад мөргөхийг шаарддаг байв. Ромчууд олон бурхдын тааллыг олж, Эзэнт Гүрнээ хамгаалуулахын тулд ийнхүү мөргөхийг шаарддаг байсан хэрэг. Гэхдээ олон бурхдыг шүтэх явдлын хамгийн гол шалтгаан бол хүн төрөлхтний нүгэлт мөн чанар байсаар ирсэн.

Хүн төрөлхтөн үнэн Бурханаасаа нүүр буруулж, хуурамч бурхад руу эргэхдээ маш амархан гэж Библид тодорхой өгүүлдэг.

Ялангуяа үүнийг гэм нүглийн тухай Библийн онол сургаалаар тайлбарладаг. Энэ нь бид агуу Бүтээгчийн бүтээл гэхээс илүү Бурханы гэм нүгэлтэй бүтээлүүд гэсэн үг юм. Гэм нүгэл бидний Бурханы бүтээлээрээ илчилсэн тэрхүү үнэнийг харах нүдийг сохолж орхидог. Тэгээд хүмүүс огт Бурхан биш зүйлсийг Бурхан эсвэл тэнгэрлэг мөн чанартай бурхад гэж эндүүрдэг. Өөрөөр хэлбэл хүмүүс жинхэнэ Бурханыг өөрсдийн ямар нэг төсөөллийн бурхдаар орлуулж орхидог гэсэн үг юм.

— Др. Давид Р. Бауэр

Дэлхий ертөнцийг ямар нэг агуу хүчит Бүтээгч бүтээсэн байх учиртайг хүн бүр зүрх сэтгэлийнхээ гүнд мэдэрдэг гэж Библид хэлсэн байдаг. Гэвч хүн төрөлх гэм нүглийнхээ улмаас үнэн Бурханыг таньж, Бүтээгч гэдгийг нь хүлээн зөвшөөрч чаддаггүй. Үүний оронд тэд Бурханы үйлсийг бусад эх сурвалжуудтай холбон тайлбарладаг. Ром номын 1:20-23 дээр Паул энэ тухай юу гэж хэлснийг сонсоцгооё. Энд:

“Ертөнц бүтээгдсэнээс хойш Түүний үл үзэгдэх мөнх хүч ба бурхан чанар нь бүтээгдсэн зүйлсээр дамжин ойлгогдож, илэрхий харагдаж байгаа тул тэдэнд шалтаг байхгүй. Гэвч тэд Бурханыг мэдсэн атлаа Бурхан гэж Түүнийг алдаршуулсан ч үгүй, Түүнд талархал өргөсөн ч үгүй. Харин ч бодол санаа нь хоосорч, ухваргүй зүрх нь харанхуй болжээ. Өөрсдийгөө мэргэн гэж хэлдэг атлаа тэд мунхаг болсон бөгөөд үл муудагч Бурханы алдрыг мууддаг хүн, шувууд, дөрвөн хөлт амьтад хийгээд мөлхөгчидтэй адил дүрээр сольжээ” гэв (Ром 1:20-23).

Паулын хэлснээр бол Библийн Бурхан оршин байдаг нь хүн бүрд илэрхий буюу тодорхой харагдаж мөн ойлгогддог гэжээ. Тэр ч бүү хэл хүн төрөлхтөн бүтээсэн бүтээлээр нь дамжуулан Бурханыг аль хэдийн таньж мэдсэн гэж Паул хэлсэн. Гэвч хүн дэндүү их гэм нүгэлтэй тул Түүнийг алдаршуулж, Түүнд талархал өргөхөөс үргэлж татгалздаг. Харин бид Бурханы алдрыг өөрсдийн бүтээсэн хуурамч бурхдаар сольж, мөргөх болсон.

Эрэгтэй, эмэгтэй, хүүхэд гээд бүх хүн зүрх сэтгэлийнхээ гүнд, оюун санаандаа, дотоод ухамсартаа Бурхан байдаг гэдгийг мэддэг гэж Библид хэлсэн. Гэвч Ром 1-р бүлэгт Адам Ева хоёр гэм нүгэлд унаснаас хойш хүн төрөлхтний зүрх сэтгэл Бурханаас эргэж, Бурханд биш Бурханы бүтээлүүдэд мөргөж эхэлсэн гэсэн байдаг. Эндээс харвал хүмүүний зүрх чухамдаа бүхий л шүтээн шүтлэгийн үйлдвэр, уг үндэс, эх сурвалж нь болсон хэрэг юм.

— Др. Самуэл Лин

Ингээд бид политеизмын тухай ярилцлаа. Одоо бүгдээрээ цорын ганц бурхан

байдаг гэж үздэг монотеизмын тухай судлахад бэлэн боллоо.

Монотеизм

Товчхондоо, монотеизмд цорын ганц бурхан байдаг гэдэгт итгэдэг бүх шашин багтдаг. Жишээлбэл, орчин цагт Иудейн шашин, Христитгэл, Исламын шашин зэрэг нь монотеизмд багтдаг. Учир нь тэд цорын ганц тэнгэрлэг бурхан байдагт итгэдэг юм.

Бичвэрийн олон хэсэгт цорын ганц Бурхан байдаг гэдгийг маш тодорхой хэлж тунхагласан байдаг. Хэдэн жишээг хамтдаа сонсоцгооё. Соломон хаан энэ тухай 1 Хаад 8:60 дээр тунхагласан байдаг. Энд:

“Өөр хэн ч биш ... Эзэн л Бурхан” гэжээ (1 Хаад 8:60).

Дуулал 86:10 дээр Давид хаан Их Эзэнд хандан дуулахдаа:

“Та бол Бурхан, Та ганцаараа” гэжээ (Дуулал 86:10).

2 Хаад 19:19 дээр Хезекиа залбирахдаа:

“Таныг Эзэн, ганц Бурхан гэдгийг мэдэх болно” гэв (2 Хаад 19:19).

Ром 3:30 дээр Паул:

“Бурхан цорын ганц” гэсэн байдаг (Ром 3:30).

Иаков 2:19 дээр Иаков ингэж хэлэхдээ:

“Бурхан бол ганц гэдэгт чи итгэдэг. Энэ чинь сайн!” гэжээ (Иаков 2:19).

Цорын ганц тэнгэрлэг оршихуй байдаг. Энэ нь Хуучин Гэрээний үед ч, Шинэ Гэрээний үед ч үнэн хэвээр байсан. Мөн Чуулганы эхний хэдэн зуунд ч энэ үнэн байсан. Энэ нь өнөөдөр ч гэсэн үнэн хэвээр л байна.

Гэхдээ цорын ганц бурхан байдаг гэдэгт итгэдэг бүх шашин нэг ижил бурханд итгэдэггүй гэдгийг энд хэлэх нь зүйтэй. Өмнө нь хэлсэнчлэн Иудейн шашин, Христитгэл, Исламын шашны аль аль нь цор ганц Бурхан байдаг гэж үздэг. Үүгээр ч зогсохгүй тэд бүгд энэхүү бурхнаа “Абрахамын Бурхан” гэж үздэг. Гэхдээ “Абрахамын Бурхан” гэдэг ойлголт нь өөр хоорондоо их ялгаатай байдаг. Бурханы мөн чанар, тэнгэрлэг үйлс, дүр төрх гээд бүх талаар тэдний итгэл үнэмшил зөрчилддөг.

Иудейн шашныг авч үзье. Иудейн шашин Христитгэлийн л нэгэн адил Хуучин Гэрээнд үндэслэдэг. Гэвч тэд Библид илчлэгдсэн Гурвалаар оршигч

Бурханыг үгүйсгэдэг. Тэд Гурвалын бодгаль бүрийг үгүйсгэдэг. Тэд Есүсийг Эзэн бөгөөд хүн болж төрсөн Бурхан гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй. Тэд Ариун Сүнснийг Бурханы нэг бодгаль гэдгийг ч үгүйсгэдэг. Ийнхүү Есүс болон Ариун Сүнснийг үгүйсгэдэг тул тэднийг илгээсэн Эцэгийг ч мөн тэд үгүйсгэдэг гэсэн үг юм. Есүс энэ талаар Лук 10:16 дээр өгүүлсэн байдаг. Энд:

“Намайг үл хэрэгсэгч нь Намайг илгээсэн Нэгэнийг үл хэрэгсэж байгаа юм гэлээ” гэжээ (Лук 10:16).

Иудейн шашин Есүс болон Ариун Сүнснийг үл хэрэгсэдэг учраас Эцэгийг ч бас үл хэрэгсэдэг.

Иудейн шашин Бурханыг Хуучин Гэрээнд заасны дагуу итгэн хүндэлдэг гэж өөрийгөө үздэг. Христитгэгчдийн хайрладаг тэр л Хуучин Гэрээг зааж, “Бид яг энэ Бурханд итгэдэг” гэж хэлдэг. Тиймээс өнгөцхөн харвал бид нэг ижил Бурханд итгэдэг мэт харагддаг. Гэвч нөгөө талаас нь харвал тэд Есүс доторх Бурханы бүрэн дүүрэн илчлэлийг үл хэрэгсэдэг тул тэд бидний итгэдэг Бурханаас өөр бурхантай гэсэн үг.

Исламын шашныг авч үзвэл тэдний Бурханы талаарх ойлголт нь Библиетэй зөрчилддөг нь маш тодорхой байдаг. 704300

Исламын шашин нь цор ганц Бурханы талаар юу гэж сургадаг вэ? Гэсэн чухал асуулт бий. Исламын шашин нь Бурханы доторх нэгдэлд ямар нэгэн байдлаар итгэдэг. Гэхдээ Христитгэл дэх Эзэний мөн чанар, зан чанарын талаарх тодорхойлолтууд нь Исламынхаас огт өөр байдаг. Бид Христийн золилт ба биежилтийн тухай онол сургаалд итгэдэг. Эдгээр нь хүмүүсийн амьдралд Эзэний мөн чанарыг маш тодорхой зааж өгдөг үндсэн сургаалууд юм. Гэтэл Муслимчуудын Бурханы нэгдлийн талаарх ойлголтод золилт ба биежилтийн аль аль нь байдаггүй.

— Др. Риад Кассис, орчуулга

Исламын шашны Бурханы талаарх ойлголт нь Библиетэй үнэхээр зөрчилддөг. Библиетэй хамгийн ихээр зөрчилддөг нэг зүйл нь Бурхан бол *ялгаагүй нэг бүхэл* гэсэн итгэл юм. Ислам шашны хувьд энэ нь юу гэсэн үг болохыг би тайлбарлахыг хичээе. Энэ бол Бурхан туйлын цор ганц тул Түүний дотор ямар ч хамтын оршихуй үгүй гэсэн үг юм. Христитгэлийн хувьд ч бас цор ганц Бурхан л буй гэсэн монотеизмд туйлын үнэнч билээ. Библийн хамгийн анхны тунхаглал бол “Сонс, Израил аа, ЭЗЭН бол бидний Бурхан бөгөөд ганц ЭЗЭН” гэсэн байдаг. Энэхүү монотеизмын тунхаглал бол анхнаасаа Иудейн Христитгэлийн теологийн уламжлал байсаар ирсэн. Тиймээс Христитгэгчид бол монотеистүүд гэсэн үг юм. Олон Ислам шашинтай найзууд маань биднийг тийм биш гэнэ. Тэд биднийг нэг биш гурван бурханд

итгэдэг гэж боддог. Тэд биднийг эцэг, эх, хүүд итгэдэг гэж бодно. Учир нь Мухаммед Бурханы талаарх Христитгэлийн онол сургаалыг буруу ойлгосон юм. Гэтэл Гурвалын тухай Христитгэлийн онол сургаал бол Эцэг, Хүү, Ариун Сүнс гэсэн гурван бодгалиар мөнхөд оршигч цорын ганц Бурханы тухай юм шүү дээ. Энэ гурвал бол нэг бурхныг гурван янзаар илэрхийлсэн гэсэн үг биш. Мөн нэг бурхныг гурван өөрөөр дүрсэлсэн гэсэн үг ч биш. Харин энэ нь цор ганц үнэн Бурхан доторх гурван бодгаль хоорондын жинхэнэ, бодит нөхөрлөл юм. Үүгээрээ энэ нь Бурханы талаарх Исламын ойлголтоос тэс өөр байдаг билээ.

— Др. Ш, Ж Лигон Дункан

Тэгэхээр Иудейн шашин, Христитгэл, Исламын аль аль нь нэг бурханд итгэдэг монотеист шашин юм. Эдгээр нь бүгд л олон бурхан байдгийг үгүйсгэдэг тул политеизмээс эрс ялгаатай. Гэвч Бурханы тухай онол сургаал нь ялгаатай байдаг учраас бие биеэсээ мөн эрс ялгаатай байдаг.

Бид политеизм ба монотеизмын тухай ярилцлаа. Одоо тэгэхээр Христитгэлийн хүлээн зөвшөөрсөн, *Элч нарын тунхаг*т бичигдсэн Бурханы талаарх ойлголтыг тайлбарлахад бэлэн боллоо.

Христитгэл

Элч нарын тунхаг дахь Бурханы талаарх ойлголт тун энгийн. Энэ нь:

**Би тэнгэр газрыг Бүтээгч,
Төгс хүчит Бурхан Эцэгт итгэдэг.. гэдэг.**

Энэхүү тунхагт Цор ганц Бурханы талаар шууд тодорхой өгүүлээгүй байгааг та анзаарсан байх. Хэрэв бид тунхгийн гарал үүслийг мэддэггүй байсан бол эдгээр үгсийг уншаад Иудейн шашны эсвэл Исламын шашны бурхны тухай ярьж байна гэж андуурч ч болох юм. Эсвэл олон бурхдын дундах нэг бурханд итгэх тухай байна гэж ойлгож ч болохоор байна. Тэгвэл бид энэ нь монотеизм ба политеизмийн тухай бус харин Христитгэлийн гурвалаар оршигч Бурханы тухай ярьж байна гэдгийг хэрхэн мэдэх вэ?

Нэг талаар тунхаг нь Бурханы талаар өгүүлсэн өөр бусад тодорхой зүйлсээр дамжуулан Христитгэлийн бус монотеизмыг үгүйсгэдэг. Өмнөх хичээлээр үзсэнчлэн тунхаг нь Ариун Гурвалын талаар өгүүлэх зохион байгуулалт бүхий бүтэцтэй. Энд Эцэг Бурхан, Түүний цорын ганц Хүү Есүс Христ ба Ариун Сүнс гэсэн нэг мөн чанарыг хуваалцах гурван тусдаа бодгалийн тухай байдаг.

Дахин хэлэхэд тунхаг нь итгэлийн дэлгэрэнгүй тунхаглал биш харин итгэлийн үндсэн хураангуй гэдгийг санаарай. Тунхгийг чуулганы ёслолд ашиглах үедээ Бурханы гурван бодгалийг ийнхүү дурдах нь Гурвалын онолын тухай ярьж байна гэдгийг бүгд мэддэг байжээ.

Нөгөө талаар тунхаг нь “бурхан” гэдэг ерөнхий үгийг тэнгэрлэг нэр болгон ганц тоон дээр бичсэнээрээ политеизмыг үгүйсгэсэн.

“Бурхан” гэдэг ерөнхий нэрээр олон зүйлийг төлөөлүүлж болно. Олон шашин өөрийн шүтдэг зүйлсийг “бурхад” гэж нэрлэдэг. Библид ч мөн “бурхан” гэдэг үгээр чөтгөр, шүтээн, удирдагчдыг ч тодорхойлон хэлсэн цөөнгүй тохиолдол бий. Тэдгээр “бурхад” нь бас өөр өөрийн гэсэн оноосон нэртэй байдаг. Жишээ нь, эртний Ромын шашинд дайны бурхныг Марс, далай тэнгисийн бурхныг Нептун, бурхдын удирдагчийг Юпитер гэдэг байв.

Үүнчлэн Библийн Бурхан ч тодорхой нэрсээр танигдсаар ирсэн. Тэдгээр нэрсийн ихэнх нь дүрсэлсэн нэр байдаг. Жишээ нь, Эл Шаддай буюу үүнийг “Төгс Хүчит Бурхан” гэж орчуулдаг. Энэ нь Бурхан бол төгс хүчит Нэгэн гэсэн утгатай үг юм. Мөн Эл Элион буюу “Хамгийн дээд Бурхан” гэж орчуулдаг. Энэ нь бүхнийг захирагч Бурхан гэсэн утгатай. Түүнчлэн Адонай гэдгийг “Эзэн” гэж орчуулдаг. Энэ нь багш ба захирагч гэсэн утгатай байна.

Гэхдээ Бурханы талаарх бидний ойлголтыг хамгийн ойр илэрхийлдэг нэр бол нь ЯВЭ гэж хэлж болох юм. Эртний орчуулгуудад энэ нэрийг Ёхова гэсэн байдаг. Харин орчин цагийн орчуулга нь ерөнхийдөө үүнийг “Эзэн” гэж орчуулсан байдаг ч энэ нь Адонай гэдгээс өөр утгатай байна.

Хүн төрөлхтний түүхийн өнө эрт үеэс Бурхан Өөрийгөө ЯВЭ гэсэн нэрээр илчилсэн байдаг. Хүн төрөлхтөн, бүр Адамын хүү Сетийн үед ч Бурханыг энэ нэрээр нь дуудаж байсан жишээг бид Эхлэл 4:26 дээрээс харж болно. Ноа Эхлэл 9:26 дээр Бурханыг ЯВЭ хэмээн дуудсан. Мөн Абрахам ч Эхлэл 12:8 дээр Бурханыг энэ нэрээр дууджээ.

Гэтлэл 3:13-14 дээр Бурхан Өөрийгөө Мосед ЯВЭ гэдэг нэрээр танилцуулсан. Энэ эшлэлийг хамтдаа харцгаая:

“Тэгэхэд Мосе, Бурханд —Хараач, би Израилийн хөвгүүд дээр очиж, тэдэнд “Эцэг өвгөдийн чинь Бурхан намайг та нар луу илгээв” гэж хэлэхэд тэд надаас “Түүний нэр хэн бэ?” гэж асуувал би тэдэнд юу гэж хэлэх вэ? гэв. Бурхан, Мосед —Би бол «Би байгаа» юм гэв. Тэгээд Тэр —Израилийн хөвгүүдэд чи “«Би байгаа» намайг та нар луу илгээв” гэж хэл гэв” (Гэтлэл 3:13-14).

ЯВЭ гэдэг нэр нь Еврей хэлний “БИ БАЙГАА” гэсэн утгатай *Эхээ* гэдэг үгнээс гаралтай. Энэ бол Бурханы ард түмэндээ Өөрийгөө илчилсэн хамгийн ойр дотно нэр бөгөөд бусад нэрсээс илүүтэйгээр Түүнийг хуурамч шүтээн, бурхдаас ялгаж өгдөг.

Үнэн хэрэгтээ бичвэр дэх Эзэнийг дууддаг бүх нэрсийн дотроос “Бурхан” гэдэг нь хамгийн ерөнхий нэр юм. Орчин цагийн Хуучин Гэрээн дэх Бурхан гэдэг үг нь ихэвчлэн Еврей хэлний Эл эсвэл Элохим гэсэн үгийн орчуулга байдаг. Харин Шинэ Гэрээнд энэ нь ихэвчлэн Грек хэлний *теос* гэсэн үгний орчуулга байдаг. Гэхдээ Библийн цаг үед бусад шашнууд ч өөрсдийн бурхдыг ийнхүү нэрлэдэг байсан. Тэгвэл яагаад Элч нарын тунхагт ЯВЭ гэдэг илүү тохиромжтой нэрийг биш харин Бурхан гэдэг ерөнхий нэрийг ашигласан юм бол оо? Учир нь “Бурхан” гэсэн ерөнхий нэрийг ашигласнаар *Элч нарын тунхаг* нь Христитгэлийн Бурхан л цорын ганц Бурхан гэж дуудуулах зохистой нь юм гэдгийг харуулахыг зорьжээ. 1 Хаад 8:60 дээр энэ тухай өгүүлдэг. Энд:

“...өөр хэн ч биш, ЭЗЭН л (Еврейгээр ЯВЭ) Бурхан...” гэжээ (1 Хаад 8:60).

Тиймээ, бусад шашнууд үнэн бодит бурхдыг шүтдэг гэж итгэдэг. Гэвч үнэндээ тэд хий хоосон зүйлсийг эсвэл чөтгөрийг буюу Христитгэлийн Бурханы захирдаг дорд, бүтээгдсэн сүнснүүдийг шүтдэг юм. Паул энэ тухай 1 Коринт 10:20 дээр тодорхой хэлсэн. Энд:

“Тэгээд ч тахидаг юмсыг тэд Бурханд [өргөдөг] бус, харин чөтгөрүүдэд өргөдөг юм” гэжээ (1 Коринт 10:20).

Хуурамч шүтээн шүтэгчид үнэндээ чөтгөрт тахил өргөж байгаагаа мэддэггүй. Тэд олон төрлийн бурхдыг л шүтэж байна гэж итгэдэг. Гэвч эндүүрч байна.

Өнөө цагт Христитгэлээс гадна олон шашин бий. Хинду, Шинто, бөө мөргөл, Викка, Ислам болон Иудейн шашин, овог аймгийн шашин шүтлэгүүд зэрэг маш олон шашин бий. Гэвч эдгээр шашны бурхад бол хуурамч юм. Тэдний зарим нь чөтгөрийг шүтдэг. Зарим нь амьгүй зүйлсийг шүтдэг. Зарим нь хийсвэр зүйлсийг шүтдэг. Харин Библид Христитгэлийн Бурхан бол жинхэнэ үнэн Бурхан. Зөвхөн Христитгэлийн Бурхан л энэ дэлхийг шүүнэ. Зөвхөн Христитгэлийн Бурхан л хүн төрөлхтнийг аврах хүчтэй гэж хэлсэн байдаг.

Элч нарын тунхгийн хамгийн эхний итгэлийн үндсэн тунхаглалд шинэ итгэгчдийг өмнөх хуурамч бурхдаа хаяж, зөвхөн Библийн Бурханыг цорын ганц үнэн Бурхан гэж хүлээн зөвшөөрөхийг уриалсан байдаг. Энэхүү дуудлага нь Библийн амин чухал сургаалыг тусган харуулдаг. Хуучин ба Шинэ Гэрээний Бурхан бол цорын ганц үнэн Бурхан гэдгийг хүлээн зөвшөөрөхийг Библи бүх эрин үеийн, бүх хүнээс шаарддаг. Мөн зөвхөн Түүнийг л хүндлэн мөргөхийг шаарддаг.

Ингээд бид Бурханы цор ганц чанарын тухай ярилцлаа. Одоо Түүний нэгдмэл чанарын тухай буюу Түүний сүнс, мөн чанарын нэгдлийн тухай үзэхэд бэлэн боллоо.

НЭГДМЭЛ ЧАНАР

Бид өмнөх хичээлээрээ Гурвалын онолыг дараах байдлаар тодорхойлсныг та бүхэн санаж байгаа байх. Энэ нь Бурхан бол гурван бодгальтай ч утгаа нэг л мөн чанартай гэсэн нь юм. Энэхүү “*бодгаль*” гэдэг нь ангид, ухамсартай хувь чанарыг хэлдэг. Харин “*мөн чанар*” гэдэг нь Бурханы үндсэн чанар эсвэл түүний оршихуйн чанарыг хэлж байгаа билээ. Тэгвэл бид Бурханы нэгдмэл чанарын тухай үзнэ гэдэг маань Түүний мөн чанар буюу үндсэн чанар, Түүний оршихуйг бүрдүүлдэг чанарын тухай ярина гэсэн үг юм.

Өнөө цагт теологичид “энгийн нэгдмэл”, “энгийн нэгдмэл чанар” гэдэг нэр томъёог мэргэжлийн үг болгон ашигладаг болсон. Энэ нь Бурханыг ойлгоход энгийн хялбар гэсэн утгаар хэлээгүй. Түүний мөн чанар нь олон өөр чанаруудын холимог биш, харин нэгдмэл нэг бүхэл чанарыг илэрхийлдэг.

Нэгдмэл чанарын тухай энэ ойлголтыг бид цэвэр усыг шавартай харьцуулах замаар тайлбарлаж болно. Өөрөөр хэлбэл цэвэр усыг энгийн нэг бүрдэлтэй гэж хэлж

болно. Энэ нь бүхэлдээ ус л байна. Өөр юу ч үгүй. Харин энэхүү цэвэр усан дээр шороо хийвэл шавар болно. Ус ба шороо гэсэн хоёр зүйлээс бүрдсэн тул шавар нь олон хэсэг бүхий бүрдэлтэй болно. Бурханы мөн чанар бол яг л цэвэр устай адил зөвхөн ганц л бүрдэлтэй байна.

Гэвч энэ яагаад тийм чухал гэж? Христитгэлд яагаад Бурхан бол олон зүйлээс бүрдээгүй нэгдмэл нэг гэж онцолдог вэ? Энэ асуултад хариулахын тулд Гурвалын онолыг дахин нэг харцгаая. Гурвалын онолд Бурхан гурван бодгальтай ч нэг л мөн чанартай гэж заасан байдаг.

Гурвалын онолын гол чухал ойлголт бол бодгаль болон мөн чанарын хоорондын ялгаа юм. Бурхан мөн чанарынхаа хувьд нэг бол бодгалийн хувьд гурав гэсэн үг. Тэгэхээр үнэндээ бид Бурханыг нэг “юу”, гурван “хэн” гэж хэлж болно гэсэн үг.

— Др. Кэйт Жонсон

Библид Бурханыг Эцэг, Хүү, Ариун Сүнс гэсэн гурван бодгальтай бөгөөд цорын ганц л Бурхан байна гэдгийг хүчтэй тунхагладаг. Эхэн үеийн чуулганы амьдралд теологичид цорын ганц Бурхан байдаг гэдгийг тайлбарлах сайн арга бол Түүний мөн чанар ба оршихуйн тухай ярих явдал гэж үзсэн. Тиймээс тэд Бурхан бол нэгдмэл нэг мөн чанартай гэж хэлэхдээ Эцэг, Хүү, Ариун Сүнс нь Гурвалын дотор нэгдсэн тус тусдаа Бурхан гэдгийг үгүйсгэдэг. Харин үүний оронд тэд энэ гурван бодгаль нь үргэлж нэгэн Бурханы дотор хамтдаа оршин байсан гэдгийг баталсан юм.

Ийнхүү бусад шашнууд Христитгэлийг гурван бурхантай хэмээн гүтгэх үед хариу болгон бид гурван Бурханд итгэдэггүй гэдгээ тодорхой болгон тайлбарлаж чадсан. Харин бид гурван бодгалиар оршдог цорын ганц тэнгэрлэг Бурханд итгэдэг.

Мусульманчуудтай ярилцахад тэд ихэнхдээ Христитгэлийн гурвалын онол бол гурван Бурханд буюу три-теизмд итгэх итгэл гэж хэлдэг. Чуулганы түүхэнд хэн ч үүнийг батлаагүй. Учир нь Эхлэлээс Илчлэл хүртэл Эцэг бол Бурхан, Хүү бол Бурхан, Ариун Сүнс бол Бурхан гэдгийг болон Бурхан бол нэг гэдгийг баталсаар ирсэн байдаг. Цорын ганц амьд, үнэн Бурхан бий. Тиймээс Бурханы бүрэн дүүрэн илчлэлийг ойлгох ганц арга зам бол “Цор ганц Бурхан байна, өөр байхгүй бөгөөд Эцэг Хүү, Ариун Сүнс нь цор ганц Бурхан дотор хамтдаа оршдог” гэж хэлэх явдал юм. Чуулган гурвалаар оршигч ганц Бурхан байдаг гэдгийг батлан хадгалсаар ирсэн тул бид гурван бурхад буй гэж үздэггүй. Ганц Бурхан байна. Гэхдээ гурван бодгальтай. Библид ийнхүү зааж, чуулган баталгаажуулснаар биднийг энэ төрлийн шашнуудаас ялгаж өгдөг.

— Др. Стефен Ж. Вэллум

Эртний өөр нэгэн тунхаг болох Никаиагийн тунхагт яг энэ санааг тун тодорхой хэлсэн байдаг:

Есүс Христ, Бурханы цорын ганц Хүү... [бол] Эцэгтэйгээ нэг мөн чанартай.

Учир нь *Элч нарын тунхаг* нь Никаиагийн тунхагаас илүү ерөнхий байдаг учраас энэ бүхнийг нарийн дэлгэрэнгүй дурдаагүй. Гэвч энэ нь би гурван бодгалиар оршигч цорын ганц Бурханд итгэдэг гэсэнээрээ уг санааг илэрхийлсэн байна.

Христитгэгчид гурван бодгалиар оршигч цор ганц Бурханд итгэх нь Христитгэлийнх нь амьдралд тоо томшгүй олон нөлөөг үзүүлдэг. Жишээ нь, уламжлалт Христитгэлийн магтаал хүндлэл гурвал дээр үндэслэсэн байдаг. Бид Гурвалын бодгаль бүрийг мөргөн хүндэлж, тус бүрд нь магтаал, залбирлын дуугаа өргөдөг. Гурвалын аль нэгийг нь хүндэлж, нөгөөг нь үл тоомсорловол Бурханыг ч үл тоомсорлож байна гэсэн үг юм. Бид Эцэг, Хүү, Ариун Сүнсний аль алиныг нь хүндлэн, үйлчилж, хайрлах ёстой. Учир нь тэд бүгд нэг л Бурхан билээ.

Бид Христитгэлийн Бурханы тухай үндсэн ойлголт болон Түүний оршихуйн мөн чанарын тухай үзлээ. Одоо бүгдээрээ *Төгс Хүчит Эцэг Бурхан* гэсэн өгүүлбэрт анхаарлаа хандуулцгаая. Библид Гурвалын эхний бодгаль болох Бурхан Эцэгийн тухай онцгойлон юу гэж заасныг авч үзье.

АГУУ ХҮЧИТ ЭЦЭГ

Төгс Хүчит Эцэгийн тухай яриагаа бид дөрвөн хэсэгт хуваан үзнэ. Нэгдүгээрт, бид Библид “Эцэг” гэдэг үгээр хэрхэн Бурханыг төлөөлүүлж байсан тухай үзнэ. Хоёрдугаарт, Бурхан Эцэгийн бодгалийг гурвалын үүднээс авч үзэх болно. Гуравдугаарт, бид Түүний Эцэгийн мөн чанарын тухай буюу Тэрээр энэхүү үүргээ хэрхэн биелүүлдэг тухай судална. Дөрөвдүгээрт, бид Түүний хүч чадлын тухай ярилцана. Ингээд, эхлээд хамтдаа Библид Бурханыг “Эцэг” хэмээн нэрлэдэг байсан тухай үзэцгээе.

НЭР

Библид “Эцэг” гэсэн нэрийг гурван өөр утга санаагаар ашигласан байдаг. Нэгдүгээрт, Бурхан бол бүхнийг бүтээгч гэсэн утгаар ашигласан. Энэ утгаар нь Шинэ Гэрээнд ашигласан нэг жишээ гэвэл 1 Коринт 8:6-р эшлэл юм. Энд Паул Эцэгийг оршин буй бүхнийг бүтээгч гэж тодорхойлсон. Бурханыг ийнхүү Эцэг хэмээн тодорхойлсон библийн тодорхойлолт бүр Гурвалын эхний бодгалийг хэлээгүй гэдгийг ойлгох нь чухал. “Эцэг” гэдэг нэрийг ашигласан хоёр дахь утга нь Бурханы охид хөвгүүд болж үрчлэгдсэн итгэгчдийн Бурхантай харилцах харилцааг

илэрхийлдэг. Паул Ром 8:15-р эшлэлд бид үрчлэлийн сүнсийг хүлээн авсан тул Бурханыг Аав аа, Эцэг минь гэж дууддаг гэж хэлэхдээ энэ хоёр дахь утгаар ашигласан байдаг. Эцэст нь, “Эцэг” гэдэг нэрийг Есүс Христ болон Бурхан Эцэгийн хоорондын онцгой харилцааг илэрхийлэхдээ ашигласан. Тэгэхээр энэ гурван утгыг нэгтгэн дүгнэвэл энэхүү “Эцэг” гэдэг нэрийг нэгдүгээрт, Бурханыг бүтээгч гэж ярихдаа, хоёрдугаарт, Бурханыг аврагч, золигч гэж хэлэхдээ, гуравдугаарт, Хүү ба Эцэгийн онцгой харилцааных нь тухай ярихдаа ашигласан гэсэн үг юм.

— Др. Кэйт Жонсон

Харамсалтай нь зарим Христитгэгчид Библид “Эцэг” гэдэг нэрийг ашигласан тохиолдлууд нь зөвхөн Гурвалын эхний бодгалийн тухай ярьж байна гэж андуурдаг. Гэвч Гурвалын онол нь Шинэ Гэрээний үе хүртэл бүрэн дүүрэн илчлэгдээгүй байв. Нэг Бурханы доторх олон бодгалийн тухай Хуучин Гэрээний энд тэнд мэр сэр сэжүүрүүд байдаг. Хэдий тийм ч Хуучин Гэрээ тэр чигээрээ Бурханы цорын ганц байдалд л голчлон анхаарсан байдаг.

Тиймээс Хуучин Гэрээнд Бурханыг “Эцэг” гэж дуудсан нь Гурвалыг бүхэлд нь илэрхийлж байгаа болохоос биш Гурвалын зөвхөн нэг бодгалийг онцлоогүй гэж ойлгож болно. Мэдээж зарим тохиолдолд “Эцэг” гэдэг нэрийг Эцэгийн бодгалийг онцлон нэрлэхдээ ашигласан нь бий. Гэхдээ Шинэ Гэрээгээр бүрэн дүүрэн илчлэн ойлгуулахаас өмнө Бурханыг дуудсан бүхий л нэр, тэр дундаа Эцэг гэдэг нэр хүртэл Гурвалыг бүхэлд нь л илэрхийлсэн байдгийг бид мартаж болохгүй. Дэд Хууль 32:6, Исаиа 63:16 болон 64:8 зэрэг эшлэлүүдэд “Эцэг” гэдэг нэрийг Бурханыг бүхэлд нь хэлэхдээ ашигласан байдаг. Илүү ойлгомжтой болгохын тулд бүгдээрээ Хуучин Гэрээний нэг жишээг хамтдаа харцгаая. Малахи 2:10 дээр эш үзүүлэгч ийнхүү асуусан байна:

“Бид бүгд нэг эцэгтэй биш үү? Биднийг нэг л Бурхан бүтээсэн биш үү?” гэжээ (Малахи 2:10).

Энд Эцэг, Хүү, Ариун Сүнсийг бүгдийг нь багтаасан нэг Бурханыг “Эцэг” гэж дуудаж байна. Учир нь энэ гурав нь хамтдаа хүн төрөлхтнийг бүтээхэд оролцсон юм. Эцэг, Хүү, Ариун Сүнсний аль аль нь өөр өөрийн үүргийг гүйцэтгэсэн гэдгийг Шинэ Гэрээнд тодорхой зааж өгсөн байдаг. Гэтэл Хуучин Гэрээний энэ эшлэлд Бурханы бодгалиудын хоорондох ялгааг төдийлөн гаргаж өгөөгүй байна. Харин бүтээлд бүгд оролцсон тул “Эцэг” гэдэг нэрээр Бурханы бодгаль бүрийг багтаан нэрлэжээ.

Шинэ Гэрээг бичсэн хүмүүс Хуучин Гэрээнээс эш татан Гурвалыг бүхэлд нь Эцэг гэдэг нэрээр ерөнхийлөн хэлсэн нь үүнийг ойлгоход бүр хүндрэлтэй болгосон байдаг. Жишээ нь, Матай 5:45, 6:6-18, Үйлс 17:24-29 зэрэг эшлэлүүдэд янз бүрийн шалтгаанаар Гурвалыг бүхэлд нь “Эцэг” гэж нэрлэсэн байдаг. Зарим тохиолдол нь Бурхан бүхлээрээ энэ дэлхийг бүтээхэд оролцсон учраас, бусад тохиолдол нь Гурвалын бодгаль бүр бидний дагах ёстой ёс зүйн хэм хэмжээ болдог учраас тийнхүү бичсэн байдаг. Илүү сайн тайлбарлахын тулд дахин нэг эшлэлийг харцгаая. Иаков 1:17 дээр юу гэснийг хамтдаа харцгаая. Энэ нь:

“Аливаа сайн соёрхол ба аливаа төгс бэлэг нь дээрээс, гэрлүүдийн Эцэгээс бууж ирдэг” гэжээ (Иаков 1:17).

Энэ эшлэлийн өмнө Иаков Бурханы зан чанар, ёс суртахуун бол цэвэр ариун байдаг тухай ярьсан. Тиймээс Бурханаас ирсэн бүх зүйл сайн, мөн бүх сайн зүйл Бурханаас ирдэг гэсэн гол санааг тэр энд хэлсэн. Сайн бүхэн гурвалаар оршигч Бурханаас ирдэг учраас Христитгэлт орчуулагч нар энэ үгийг Гурвалыг бүхэлд нь ярьж байна гэж ойлгодог. Мэдээж Хуучин Гэрээний л нэгэн адил энд ч бас Эцэг гэдэг бодгалийг илүү чухалчилдаг нь учиртай. Гэхдээ Хүү, Ариун Сүнс хоёр ч бас бидэнд сайн зүйлсийг өгдөг гэдгийг ойлгож итгэх нь чухал.

Үүнээс гадна Библид “Эцэг” гэдэг нэрийг Хүү, Ариун Сүнс хоёроос тусдаа зөвхөн Эцэгийн тухай ярихдаа ашигласан байдаг. Иохан 1:14, 18; Иохан 5:17-26, Галат 4:6 болон 2 Петр 1:17 гэх мэт эшлэлүүдээс жишээ татан харж болно. Илүү ойлгомжтой болгохын тулд дахиад хоёр эшлэлийг авч үзье. 2 Иохан 9 дээр элч Иохан Эцэг болон Хүүг тусад нь салгаж бичсэн байдаг. Энд:

“Хэтэрч, Христийн сургаал дор байдаггүй хэнд ч Бурхан байхгүй. Сургаал дотор байгч хүнд Эцэг ч, Хүү ч байна” гэжээ (2 Иохан 9).

Иохан 14:16-17 дээр Есүс элч нартаа энэ амлалтыг өгөх үедээ Эцэг болон Ариун Сүнс хоёрыг тусад нь ялгаж бичсэн:

“Би Эцэгээс гуйхад Тэр та нарт өөр Туслагчийг өгнө. Тэр нь та нартай үүрд хамт байна. Тэр бол үнэний Сүнс..” гэжээ (Иохан 14:16-17)

Ингээд бүгдээрээ Библид “Эцэг” гэдэг үгийг Бурханыг бүхэлд нь хэлэхдээ, мөн Гурвалын эхний бодгалийг онцлон ярихдаа ашигласан тухай үзлээ. Одоо тэгвэл Гурвалын бусад бодгалиас Бурхан Эцэг гэдэг бодгаль нь ямар ялгаатай болохыг үзэхэд бэлэн боллоо.

БОДГАЛЬ

Хүү ба Ариун Сүнсстэй харилцах Эцэгийн харилцааг олон янзаар тайлбарласан байдаг. Гэхдээ теологийн түүхэнд бол Гурвалын талаар хоёр онол голлон давамгайлсаар ирсэн. Ялангуяа Гурвалын онтологи (оршихуй), Гурвалын экономик (зохион байгуулалт) онол гэж ярих нь их түгээмэл байсан. Энэ хоёр үзэл хоёулаа нэгэн ижил Гурвалын тухай буюу Эцэг, Хүү, Ариун Сүнсний тухай боловч Бурханы доторх гурван бодгаль хоорондох харилцааны өөр өөр талуудыг онцолдог гэсэн үг.

Нэг талаар Бурханы оршихуйд анхаарлаа хандуулах үед Гурвалын онтологийн тухай ярих нь их байсан. Онтологи гэдэг нь оршин буйтай холбоотой гэсэн утгатай үг юм. Тиймээс бид Гурвалын онтологи гэж яривал Гурвалын оршихуй эсвэл мөн чанарын тухай ярьж байна гэсэн үг. Бид Гурвалын гурван

бодгаль хоорондоо хэрхэн харилцаж, нэг мөн чанарыг хэрхэн хуваалцан оршдог тухай ярьж байна.

Онтологийн онолоор бол Бурханы гурван бодгаль гурвуулаа цаглашгүй, мөнхийн бас хувиршгүй юм. Мөн бодгаль бүр мэргэн ухаан, хүч чадал, цэвэр ариун байдал, шударга ёс, сайн сайхан, үнэн зэрэг чухал тэнгэрлэг чанаруудтай.

Нөгөө талаас, бид Бурханы бодгалиуд нь бие даасан бодгалийн хувьд бие биетэйгээ хэрхэн харилцдаг тухай ярихдаа Гурвалын экономик онолын үүднээс ярьж байна гэсэн үг юм. Экономик гэдэг үг нь айл өрхийн зохион байгуулалттай холбоотой. Тиймээс Гурвалын тухай экономик талаас нь ярьж байна гэдэг нь Эцэг, Хүү, Ариун Сүнсний аль аль нь тус тусдаа бодгаль гэдэг үүднээс бие биетэйгээ хэрхэн харилцдаг тухай тайлбарлаж байна гэсэн үг юм.

Гурвалын экономик үзлээр бол бодгаль бүр өөр өөр үүрэг хариуцлагатай, өөр өөр түвшний эрх мэдэлтэй, өөр өөр гүйцэтгэх үүрэгтэй байдаг. Мөн Эцэг, Хүү, Ариун Сүнс гурав хоорондоо ярилцдаг. Тэд хоорондоо санал нийлж, бие биедээ хариу үйлдэл үзүүлдэг гэх мэт маш олон янзаар харилцдаг.

Гурвалын онтологийн болон экономик онолын аль аль нь Бурхан Эцэгийг эхний бодгаль гэж үздэг. Гурвалын онтологийн үзлээр Хүү нь Эцэгээс бий болсон, Ариун Сүнс ч гэсэн Эцэгээс үүдэлтэй тул Эцэг нь эхний бодгаль гэж үздэг.

1 Иохан 4:9 дээр Хүүгийн үе удмын тухай юу гэж хэлснийг авч үзье. Энд:

“Бурхан цорын ганц Хүүгээ ертөнцөд илгээсэн нь Түүгээр дамжуулан биднийг амьд байлгахын тулд юм” гэжээ (1 Иохан 4:9).

“Цорын ганц” гэдэг үг нь Грек хэлний *моногенес* гэдэг үгнээс гаралтай бөгөөд ихэвчлэн “цорын ганц бүтээгдсэн буюу төрсөн” гэж орчуулагддаг. Харамсалтай нь чуулганы эхэн үеийн зарим хүмүүс энэ үгийг Хүү бүтээгдсэн учир Хүү бүрэн дүүрэн Бурхан биш хэмээн үзсэн. Өнөөдөр ч зарим нэг гаж урсгалууд “бүтээгдсэн” гэдэг энэ үгнээс болоод Хүүгийн Бурханлаг чанарыг үгүйсгэдэг.

Энэ буруу сургаалыг залруулахын тулд Христитгэгчид Хүү бол мөнхөөр бүтээгдсэн эсвэл Эцэгээс мөнхөд бий болсон гэж хэлдэг уламжлал тогтсон. Эдгээр үг хэллэгүүд нь Хүүг оршин байгаагүй цаг хугацаа үгүй гэдгийг ойлгуулахыг зорьсон юм. Иохан 15:26 дээр Ариун Сүнс хаанаас ирсэн тухай Есүс юу гэж хэлснийг сонсоцгооё. Энэ нь:

“Би Эцэгээсээ та нарт Туслагчийг илгээнэ. Тэр бол Эцэгээс гарах үнэний Сүнс мөн. Тэр ирэхдээ Намайг гэрчилнэ” гэжээ (Иохан 15:26).

Энд буй “гарах” гэдэг үг нь Грек хэлний *екпорейомай* гэсэн үг ба ихэнхдээ үүнийг “үүсэх” гэж тайлбарладаг. Уламжлал ёсоор энэ эшлэлийг Ариун Сүнсний оршихуйн эх үндсийг хэлж байна гэж ойлгосоор ирсэн.

Харамсалтай нь энэ мэт эшлэлүүдийн улмаас зарим хүмүүс Ариун Сүнсийг мөнх биш эсвэл бүрэн дүүрэн Бурхан биш хэмээн буруугаар ойлгох нь бий. Тиймээс уламжлалт Христитгэлийн теологи Ариун Сүнсийг Гурвалын нэг бодгаль, Эцэгээс мөнхөд гаралтай хэдий ч бүрэн дүүрэн Бурхан гэж тун болгоомжтойгоор заасаар ирсэн.

Эцэг Бурханыг Гурвалын онтологийн буюу оршихуйн хувьд эхний бодгаль

гэж үзэхээс гадна Гурвалын экономик буюу зохион байгуулалтын хувьд ч мөн эхний бодгаль гэж үздэг. Эцэг хүн гэр бүлийнхээ дээр эрх мэдэлтэй байдаг шиг Гурвалын зохион байгуулалтын хувьд ч Эцэг Бурхан бол нөгөө хоёр бодгалийнхаа дээгүүр эрх мэдэлтэй гэж үздэг. Тиймээс Түүнийг Гурвалын “эхний бодгаль” гэж үздэг.

Бид Эцэг Бурхан Хүүгийн дээгүүр эрх мэдэлтэй болохыг олон талаар хардаг. Жишээ нь, Хүү Эцэгийнхээ хүслийг биелүүлж байгааг бид Иохан 6:40 дээрээс харж болно. Мөн Хүү эрх мэдэл, хаанчлалаа Эцэгээс өвлөн авч буй талаар Ефес 1:20-22 зэрэг эшлэлүүдэд бий. Үнэндээ Хүүгийн хаанчлал Эцэгийн эрх мэдэл дор байдгийг Библи бидэнд ахин дахин сануулсан байдаг. Есүс Бурханы баруун мутарт, Бурханы хаан сэнтийн баруун талд залран буйг Дуулал 110:1, Еврей 1:3 зэрэг олон эшлэлээс бид хардаг. Бурханы баруун мутар бол хүндэтгэл, хүч чадлын байр суурь боловч хаан сэнтий биш юм. 1 Коринт 15:24 дээр Паулын хэлсэнчлэн эцсийн эцэст Хүү хаанчлалаа Эцэгтээ дамжуулан өгнө. Товчхондоо Гурвалын зохион байгуулалтын хувьд Эцэг нь Хүүгийн дээр эрх мэдэлтэй гэсэн үг.

Эцэг Хүүгийн харилцаа болон эрх мэдлийн тухай асуулт бол эдрээтэй асуулт юм. Гурвалын дотор гүйцэтгэх Эцэг, Хүүгийн үүргийн ялгаатай байдлаас чухамдаа хамаардаг гэж хэлж болно. Хүүгийн үүрэг нь Эцэгтээ сайн дураараа дуулгавартай байж үйлчлэх юм. Тэрээр энэ дэлхийд Эцэгийнхээ хүслийг биелүүлэхийн тулд ирсэн бөгөөд эрх мэдлийг нь дуулгавартай дагадаг байв. Гэвч Гурвалын дотор Эцэг Хүүгээ хайрлаж, Хүү нь Эцэгээ хайрлаж, бие биеэ хүндэлдэг хайрын харилцаа ч мөн байсан. Тиймээс бид тэдний гүйцэтгэдэг үүрэг, тэдний бие биеэ хайрласан харилцааны учрыг нарийн ялгаж салгаж ойлгох нь зүйтэй.

— Др. Симон Виберт

Үүнчлэн Эцэг мөн Ариун Сүнсний дээгүүр эрх мэдэлтэй юм. Жишээ нь Лук 11:13 болон Ефес 1:17 зэрэг эшлэлүүдээс бид Ариун Сүнсийг Эцэг илгээдэг гэдгийг олж мэддэг. Мөн Үйлс 10:38 дээр бид Эцэг нь Хүүгээ Ариун Сүнсээр хүчирхэгжүүлснийг хардаг. Ариун Сүнс энэ дэлхийд Эцэгийг төлөөлж, Эцэгийн хүслийг биелүүлэхийн тулд зааврыг нь дагадаг тухай Библиэр дүүрэн бий. Гурвал зохион байгуулалтад Эцэг нь Хүүгийн дээгүүр эрх мэдэлтэй байсны адил Ариун Сүнсний ч дээгүүр эрх мэдэлтэй гэж үздэг.

Эцэгийн эрх мэдэл бол үргэлж хайрын эрх мэдэл байдаг. Эцэгийн эрх мэдэл бол Хүүгээ хайрлаж, Хүүгээ алдаршуулахыг хүсдэг хайр юм. Хүү ч бас Эцэгээ алдаршуулахыг хүсдэг. Тэгээд эцэст нь Эцэг, Хүү, Ариун Сүнс гурав бие биеэ хайрладаг. Энэ талаас нь харвал Эцэг, Хүү, Ариун Сүнс гурвын хүсэл хоорондоо зөрчилдвөл яах вэ гэж бодогддог. Гэтэл үнэндээ Хүү, Ариун Сүнс хоёулаа үүрд мөнхөд Эцэгийн хүслийг биелүүлж, Эцэгийг үүрд мөнхөд алдаршуулахыг хүсдэг. Тиймээс Бурханы хувьд хамгийн чухал зүйл бол Гурвалын нөхөрлөлийн доторх хүсэл зорилгын нэгдэл, хайрын нэгдэл,

оршихуйн нэгдэл байдаг юм.

— Др. Стив Блэйкмор

Ингээд бид “Эцэг” гэдэг нэрийг хэрхэн ашигладаг тухай, мөн Бурхан Эцэгийн бодгалийн тухай ойлголттой боллоо. Одоо бид Бурхан бүтээлүүдийнхээ болон хүн төрөлхтөнд хэрхэн Эцэг нь болдог тухай үзэхэд бэлэн боллоо.

ЭЦЭГ БАЙХУЙ

Бид Бурханы Эцэг байхуйн тухай нарийн тайлбарлахаас урьтаж Бурхан Өөрийн Гурвалын мөн чанарыг илчлэхээс ч өмнө Хуучин Гэрээнд Түүний Эцэг байхуйн талаар өгүүлсэн хэд хэдэн хэсгээс онцолж үзэх нь зүйтэй. Тэдгээр эшлэлүүд дэх “Эцэг” гэдэг үг нь юун түүрүүнд голчлон Эцэгийн бодгалийн тухай биш, харин Гурвалыг бүхэлд нь ярьсан байдаг.

Хэдий тийм ч Шинэ Гэрээнд Түүний Эцэг байхуйн чанарыг ихэнхдээ Эцэгийн бодгальтай холбон тайлбарладаг. Тиймээс Хуучин Гэрээнээс ч бас Эцэгийн бодгалийг илүүтэй онцолсон хэсгүүдийг унших нь зүйтэй юм.

Түүний Эцэг байхуйн чанарыг бид олон талаас нь ярилцаж болно. Гэвч бид Библид илүү ойлгомжтой зааж өгсөн гурван санааг авч үзнэ. Нэгдүгээрт, Эцэгийн үүргийг *бүтээгч* талаас нь авч үзнэ. Хоёрдугаарт, Түүний бүтээлүүд ба хүмүүсийнхээ хаан болох байр суурийг нь авч үзнэ. Гуравдугаарт, Бурхан Эцэг бол хүмүүсийнхээ хувьд айл өрхийн тэргүүн мэт байдаг гэсэн санааг судалж мэднэ. Ингээд эхлээд Түүний бүтээгчийн үүрэг оролцоог Эцэг байхуйтай нь холбон үзэцгээе.

Бүтээгч

Бичвэрт Бурханыг өргөн утгаар нь бүтээсэн бүгдийнхээ Эцэг нь хэмээн тодорхойлдог. Тухайлбал, Дэд хууль 32:6, Исаиа 43:6-7, 64:8, Малахи 2:10, Лук 3:38 зэрэг эшлэлүүдээс бид энэ жишээг харж болно.

Ганц жишээ дурдахад, Үйлс 17:26-28 дээр Паул энэ талаар Афинчуудад хандан хэлсэн байдаг. Энэ нь:

“Бурхан газрын цээжээр амьдруулахаар нэг хүнээс хүмүүн төрөлхтний үндэстэн бүрийг бүтээж, тэдний цаг хугацаа болон нутаглах хил хязгаарыг тогтоож өгсөн нь... Танай зарим яруу найрагчдын “Бид бас Түүний үр удам” гэж хэлсэнчлэн...” гэжээ (Үйлс 17:26-28).

Энд Паул өөр шашинтай яруу найрагч нар болох Клинтес болон Аратус нараас эш татсан бөгөөд тэд Зевсийг хүнийг бүтээсэн учраас хүн төрөлхтний эцэг гэж үздэг байв. Мэдээж Паул Библийн Бурхан л жинхэнэ бүтээгч, харин Зевс биш гэдгийг нотолсон. Мөн Паул бүтээгч нь бүтээлийнхээ эцэг болдог гэсэн санааг энд баталж өгсөн юм.

Библийг хүмүүний хэлээр бичсэн шүү дээ. Бидний Бүтээгч Бурхантай харилцах харилцааг ихэвчлэн эцэг ба хүүхдийн харилцаагаар илэрхийлдэг. Энэ ч утгаараа Бурхан бидний Эцэг гэдэг нь бидний гарал үүсэл болон Түүний эрх мэдлийг харуулдаг.

— Др. Паул Чан, орчуулга

Эцэг хүн үр хүүхдүүдээ тэвчээртэй ханддаг шиг Бурхан бүтээлүүдийнхээ Эцэг учраас унасан дэлхийд, ялангуяа нүгэлт хүн төрөлхтөнд туйлын тэвчээртэй ханддаг юм. Энэ нь Тэр бүтээлүүдээ хэзээ ч шүүхгүй гэсэн үг биш. Харин Бурхан уурлахдаа удаа, өршөөл нигүүлслээ үзүүлэхдээ хурдан байдгийг тайлбарлахад тусалдаг юм. Бид Дуулал 145:8-9-р эшлэлээс энэ тухай харж болно. Энд:

“ЭЗЭН нигүүлсэнгүй хийгээд өршөөнгүй, уурлахдаа удаан, хайр энэрлээр аугаа их юм. ЭЗЭН бүгдэд сайн. Түүний өршөөлүүд бүтээл бүхнийх нь дээр байна” гэжээ (Дуулал 145:8-9).

Ингээд бид Бурханы бүтээгч үүргийг нь авч үзлээ. Одоо бүгдээрээ Бурханы хаан байх үүрэг нь Түүний Эцэг байхтай нь хэрхэн холбогдож байгааг харцгаая.

Хаан

Эртний ойрх дорнодод хүмүүс хаан эзнээ эцэг гэж дуудах, хаан эзэн нь ард түмнээ үр хүүхдүүдээ гэж хэлэх нь нийтлэг байв. Энэ хэллэг нь Библид ч мөн тусгалаа олсон. Жишээ нь, Израильчууд хаан Давидыг өөрсдийн эцэг гэж дуудсан байдаг. Мэдээж зарим Израильчууд Давидын удмын хүмүүс байсан учраас түүнийг өвөг эцгээ хэмээх нь зүйн ёсны хэрэг. Харин бүхэл бүтэн нэг үндэстэн Давидыг өөрсдийн эцэг гэж дуудсан нь тэрээр тэдний хаан байсан гэсэн утгатай юм. Марк 11:10 дээр цугларсан олон хэрхэн хашхирсныг сонсоцгооё. Энд:

“Эцэг Давидын маань айсуу хаанчлал ерөөлтэй еэ!” гэжээ (Марк 11:10).

Давид Израилийн эцэг болсон нь түүний хаан байсантай шууд холбоотой юм. Үүнчлэн Үйлс 4:25-26 дээр чуулган Бурханыг ийнхүү магтсан байна. Энэ нь:

“Та Өөрийн зарц, бидний өвөг, Давидын амаар дамжуулан Ариун Сүнсээр айлдахдаа, “Юунд харийнхан уурсаж, ард түмнүүд дэмий зүйл сэднэ вэ? Эзэн ба Түүний Христийн эсрэг газар дэлхийн хаад сууцгааж, захирагчид цугларцгаав” гэжээ (Үйлс 4:25-26).

Энэ эшлэлд Давидыг дахин Израилийн эцэг хэмээжээ. Учир нь тэрээр Эзэнээр тослогдож, Түүний хаан ширээнд заларсан, Израилийг дайснуудынх нь эсрэг тулаанд удирдсан нэгэн байсан юм. Тэгвэл эртний хүмүүс яагаад хаанаа өөрсдийн

эцэг гэж дууддаг байсан юм бол?

Эртний хаад ард түмэндээ санаа тавьж, хэрэгцээт зүйлсээр нь хангаж, хамгаалах зэрэг эцэг ёсны олон үүргийг хүлээдэг байжээ. Тиймээс хаад өөрсдийгөө ард түмний “эцэг” гэж нэрлэдэг байв. Гэвч бодит байдал дээр эдгээр нь тэдний суртал ухуулга төдий байсан. Учир нь эртний хаад өөрсдийн ард түмэндээ үйлчлэхээс илүүтэй өөрсдөдөө л үйлчилдэг байсныг харж болно. Харин яг тэр цаг үед Бурхан Өөрийгөө Израильд илчлэхдээ хаан бол эцэг юм гэсэн ойлголтоор нь дамжуулан илчилжээ. Харин Бурхан бидний Эцэг, эрхэм дээд Эцэг, хаан язгуурт Эцэг гэдэг нь огтхон ч суртал ухуулга биш юм. Энэ бол үнэн. Бурхан бидэнд анхаарал тавьдаг. Тэр бидний хэрэгцээг хангадаг. Тэр яг л эцэг хүн шиг биднийг хамгаалдаг. Тиймээс тэр бол хаант улсынхаа, эзэнт гүрнийхээ Эцэг нь мөн.

— Др. Ричард Л. Праг, Жр

Хүн төрөлхтний хаад улс үндэстнийхээ эцэг гэж дуудагдаж байсанчлан Бурхан энэ дэлхийн хаадыг захирдаг агуу хаан, сонгогдсон үндэстэн Израилийг шууд захирагч байсан учраас “Эцэг” гэж дуудагддаг юм.

Исаиа 63:15-16 дээр Эзэний Эцэг хүний чанарынх нь тухай юу гэж хэлснийг сонсоцгооё. Энэ нь:

“Тэнгэрээс доош харж, ариун, цог жавхлант газраасаа үзээч. Таны зүтгэл, Таны хүчит үйлс хаана байна вэ? Надад хандсан Таны сэтгэл өрөвдөл өршөөл тань надаас холджээ... Харин Та л бидний Эцэг билээ. Эртнээс Таны нэр бол Золигч” гэжээ (Исаиа 63:15-16).

Энэ эшлэлд Бурханыг “Эцэг” хэмээн тодорхойлжээ. Учир нь Тэрээр тэнгэрлэг хаан сэнтийдээ залран, бүх бүтээл хийгээд Израиль ба Иудаг онцгой замаар удирдан захирсан. Ялангуяа, тэнгэрлэг хааны зорилго бол цэргээ удирдан тулаанд орж, дайснаа дарж, ард түмнээ хамгаалах явдал юм.

Эцэг хүн үр хүүхдүүдээ халамжилдаг шиг тэнгэрлэг Хаан маань биднийг тийнхүү анхаардаг гэж бодохоор асар их итгэл ба амар тайван ирэх нь дамжиггүй. Бид өөрийн хүчээр энэ дэлхийн ёрын муутай тэмцэж хүчрэхгүй. Гэвч тэнгэрлэг Хаан биднийг эцэг шиг хайрлан, туслахад үргэлж бэлэн байдаг билээ.

Чухамдаа энэ бол Есүсийн заасан гуйлт дахь нэг санаа юм. Тэрээр шавь нартаа “Тэнгэх дэх Эцэг”-гээ хандан залбирахыг зааварласан. Энэхүү Эзэний заасан гуйлтад Бурханыг бидний тэнгэр дэх Эцэг гэж хэлсэн байна. Библи дэх тэнгэрийн тухай дүрслэл бүгд адил байдаг. Өөрөөр хэлбэл тэнгэрийн улс бол Бурханы хаан сэнтийд заларч, ард түмнээ захирах тэрхүү газар юм. Тиймээс Есүс дагалдагч нартаа “Тэнгэр дэх Эцэг минь” хэмээн залбир гэсэн нь тэнгэрт залран буй Хаан болох эрхэм дээд Эцэгтээ хандан залбираарай гэсэн утгатай байдаг. Бурхан бидэнд өдөр тутмын

маань хүнсийг өгч, өрийг маань уучлан, сорилтоос хамгаалж, бузар муугаас гэтэлгэнэ гэдэг итгэл маань Тэр бол биднийг хайрладаг Хаан ба Түүнд бидний төлөө эдгээрийг хийх хүсэл ба хүч чадал бий гэдэгт суурилдаг юм.

Бурханыг Бүтээгч болон Хаан гэдэг талаас нь ойлгож мэдсэн учраас одоо Түүний Эцэг байхуйн мөн чанарын нэгэн тал болох өрхийн тэргүүний үүргийнх нь тухай ярилцахад бэлэн боллоо.

Өрхийн Тэргүүн

Теологид пасторын хүний үүргийн талаар үргэлж байсаар ирсэн нь миний сонирхлыг татдаг. Бидний итгэл биднийг хэн болж төлөвшихөд нөлөөлдөг шүү дээ. Бурхан Эцэгийг хүндлэх тухайд ч бас адил. Сайн эцэгтэй байсан, байгаагүй хүмүүсийн хувьд энэ бол хоёр талтай асуудал. Миний хувьд аав маань сайн аав байсан азтай хүн. Тиймээс Бурханыг тэнгэрлэг Эцэг минь гэж хүлээн авахад амархан байсан. Аавын маань хэлсэн үг бүхэн, миний төлөө хийсэн бүхэн, аавтайгаа харилцах харилцаа маань амьдралд маань ач тусаа өгсөн учраас Бурхан Эцэгийг эергээр хүлээн авахад маань чухал нөлөөтэй байсан. Гэвч олон жилийн турш хүмүүстэй ажилласан туршлагаараа би аавтайгаа сөрөг харилцаатай байсан хүмүүсийн хувьд энэ нь маш хэцүү гэдгийг ойлгосон юм. Нэг өдөр оюутнуудын маань нэг хүрч ирээд “Бурхан миний хэзээ ч байгаагүй аав минь болсон” гэсэн үг надад их өөр ойлголтыг өгсөн. Тэгэхээр бид Бурханы *эцгийн зурх* сэтгэлийг ойлгож мэдсэнээр төрсөн эцэг маань сайн муу байснаас үл хамааран, хэчнээн хэцүү байсан ч эцэстээ Бурхан биднийг хайрладаг гэдгийг ойлгох боломжтой юм.

— Др. Стив Харпер

Өрхийн тэргүүн гэдэг ойлголтыг мэдэхгүй хүн гэж бараг үгүй биз ээ. Ихэнхдээ эцэг эх, эмээ өвөө эсвэл бусад хамаатан садан нь тухайн гэр бүлийг удирдаж, шийдвэр гаргадаг. Тэгэхээр Библид Бурханы хүмүүстэйгээ харилцдаг харилцааг яг ийм маягаар дүрсэлсэн байх нь олон.

Хуучин Гэрээний цаг үед Бурханыг нэгэн улс үндэстний Тэргүүн гэж үзэж байсныг бид олж харж болно. Жишээ нь, Эхлэл 5:1-3 дээр Мосе Бурхан болон Адамтай харилцах харилцааг Адам хүү Сеттэйгээ харилцах харилцаатай адилтган дүрсэлсэн нь бий.

Мөн Хуучин Гэрээнд Бурханыг ихэнхдээ Израилийн Тэргүүн гэж дүрсэлсэн байдаг. Дэд хууль 1:31, Дуулал 103:13, болон Сургаалт үгс 3:12 зэрэг эшлэлүүдэд Бурханы ард түмэндээ үзүүлж байгаа халамжаас үүнийг бид харж болно. Хосеа 11:1 дээрх Эзэний хэлсэн үгийг харцгаая. Энэ нь:

“Израилыг залуу байх үед Би түүнийг хайрласан. Хүүгээ Египетээс дуудан гаргасан” гэжээ (Хосеа 11:1).

Энэ эшлэлд Эзэн Израилийг бага балчраас нь хайрласан эцэг хүний адилаар өөрийгөө дүрсэлсэн байна. Мөн Тооллого 12:7 дээр Бурханыг Израилийн өрхийн Тэргүүн гэж хэлсэн байдаг. Энд Эзэн Мосед хандан ийнхүү хэлсэн:

“Миний зарц Мосегийн хувьд тийм биш бөгөөд тэр миний бүхий л гэрт итгэмжит билээ” гэв (Тооллого 12:7).

Энэхүү “Гэр” гэдэг нь Еврей хэлний *Баит* гэдэг үг юм. Еврей хэлний энэ үг зөвхөн байр байшинг биш, байшин дотор нь амьдардаг хүмүүсийг илэрхийлдэг. Энд Мосег өрхийн тэргүүнийхээ хүмүүс ба эд хөрөнгийг нь хариуцан захирдаг хүү эсвэл зарц хэмээн дүрсэлжээ. Үүгээр Бурхан бол Израиль Үндэстний өрхийн Тэргүүн гэсэн цаад санааг харуулсан байдаг.

Мэдээж Бурханыг өрхийн Тэргүүн гэсэн тодорхойлолт Шинэ Гэрээнд ч бас бий. Бурхан Эцэг бидний гуйлгад яг л эцэг хүн хүүхдүүддээ хариулж байгаатай адил хариулдаг гэж Есүс Матай 7:9-11, Лук 11:11-13 дээр заасан. Бид Бурханы гэр бүлийн гишүүд болсон тул Эцэг биднийг хайрладаг хэмээн Иохан 1:12-13, мөн 1 Иохан 2:29 болон 3:1 дээр өгүүлдэг. Эцэг хүн үр хүүхдээ сахилгажуулдагтай адил Бурхан бидний сайн сайхны төлөө биднийг сахилгажуулдаг гэж Еврей 12:5-10 дээр хэлсэн. Чуулганыг Бурханы гэр ба гэр бүл гэж 1 Тимот 3:15, 1 Петр 4:17 зэрэг эшлэлүүдэд тодорхойлсон байдаг.

Бурханы Эцэг байхуйн чанар нь пасторын үүрэгт онцгой ач холбогдолтой гэж би боддог. Хамгийн наад зах нь л гэхэд Бурхан бол Эцэг. Өөрөөр хэлбэл Библид Эцэг ямар байдаг, мөн Бурхан ямар байдаг нь үнэхээр гайхалтай харагддаг. Тиймээс бид Бурханд гэр бүл гэдэг ямар их чухал болохыг харж болно. Дэд хууль 6-р бүлэгт “Сонс, би Бурханы хууль болон хайрыг гэр бүлүүдээр дамжуулан сахин хамгаална” гэж хэлсэн нь ийм учиртай. Эцэг эхчүүд амьдралаа үр хүүхдүүддээ өвлүүлэн өгч, энэ холбоос тасрахгүй гэсэн үг. Тэнд л гайхалтай зүйл болдог нь тодорхой. Бурханд гэр бүл маш чухал. Үүнчлэн гэр бүлд ч эцэг хүний үүрэг туйлын чухал байдаг. Тэнд пасторын үүрэг нөлөө байх ба дэлхий даяар хаана эцгүүд хүчтэй байна, тэнд соёл нь хүчтэй байдаг. Эцгүүдийн үүрэг сулраад ирвэл соёл нь доройтож эхэлдэг. Эцэг хүнийг ээж нь орлох боломжгүй. Мэдээж бидэнд бас сайн ээжүүд зайлшгүй хэрэгтэй. Гэвч эцэг хүний орон зайг юугаар ч нөхөх боломжгүй юм. Бурханы Эцэгийн үүрэг ч мөн тийнхүү хүчтэй нөлөөтэй байна. Эцэг хүний үүрэг оролцоо суларвал хүчирхийлэл гэмт хэрэг газар авч, боловсрол доройтдог болохыг би хардаг. Тиймээс Эцэг хүний үүрэг оролцоо суларвал тэр соёл тэр чигээрээ замбараагүй болж, буруу зам уруу ордог. Бурханыг Эцэг гэж ойлгохгүй бол ийм л зүйл болно.

— Др. Матт Фрайдемэн

Ингээд бүгдээрээ Төгс хүчит Эцэг Бурханы нэр ба бодгаль болон Эцэг байхуйн талаар судалж мэдлээ. Одоо Бурханы хүсэл зорилгоо биелүүлдэг хязгааргүй хүч чадлынх нь тухай судалцгаая.

ХҮЧ ЧАДАЛ

Элч нарын тунхаг дахь хамгийн эхний итгэлийн үндсэн тунхаглалыг дахин нэг харцгаая. Энэ нь:

**Би тэнгэр газрыг Бүтээгч
Төгс хүчит Эцэг Бурханд итгэдэг.**

Энэхүү *Элч нарын тунхагт* Бурхан Эцэгийг *төгс хүчит* гэсэн нь Түүний хүч чадал хязгааргүй бөгөөд хэнтэй ч зүйрлэшгүй гэсэн үг юм. Уламжлалт теологийн нэр томъёонд Бурханы төгс хүчит хүч чадал гэдэг нь Түүний Омнипотенс буюу *бүхнийг чадагч* чанарыг илтгэдэг. *Омни* гэдэг үгийн үндэс нь бүх гэсэн утгатай, *потенс* гэдэг нь хүч чадал гэсэн утгатай үг юм.

Эцэгийн хүч чадал бол хязгааргүй юм. Учир нь Түүнд хүссэн зүйлээ хийх хүч бас чадвар бий. Зөвхөн Түүнд л ийм хүч чадал байдаг тул Түүнтэй зүйрлэх хэн ч үгүй билээ.

Эцэгийн хүч чадлын хязгааргүй бас хэнтэй ч зүйрлэшгүй чанарыг бид илүү нарийвчлан үзэх болно. Тэгэхээр эхлээд Түүний хүч чадлын хязгааргүй мөн чанарын тухай ярилцъя.

Хязгааргүй хүч чадал

Бичвэрт Эцэгийг хүссэн бүхнээ хийх хүч чадалтай гэж дүрсэлсэн байдаг бөгөөд Түүний энэ хязгааргүй хүч чадлыг олон талаас нь тайлбарладаг. Энд Түүнийг ертөнцийг бүтээх бас устгах чадалтай гэдэг. Түүнд цаг агаарыг захирах, тулаанд дайснуудаа ялах, хүн төрөлхтний засаг төрийг удирдан засаглах, хүчит гайхамшгуудыг үйлдэх, Өөрийн хүмүүсийг аврах хүч чадал бий. Иеремиа 10:10-16 дээр эш үзүүлэгч Иеремиа Эзэнийг ийнхүү дүрсэлсэн байдаг. Энд:

“Харин ЭЗЭН бол жинхэнэ Бурхан. Тэр амьд Бурхан бөгөөд мөнхийн Хаан. Уур хилэнд нь дэлхий хөдөлж, үндэстнүүд дургүйцлийг нь тэсэж чаддаггүй...хүч чадлаараа дэлхийг бий болгож, мэргэн ухаанаар ертөнцийг Тэр тогтоосон билээ. Түүний ухаанаар тэнгэрс тэлсэн билээ.

13 Түүнийг дуугарахад тэнгэрс дээр ус хүржигнэдэг бөгөөд Тэрээр дэлхийн төгсгөлөөс үүлсийг хөөргөдөг. Тэрээр бороонд зориулж цахилгаан бүтээж, агуулахуудаасаа салхийг гаргадаг... Учир нь Тэрээр

бүхнийг Бүтээгч бөгөөд Израил нь Түүний өвийн овог юм.
Түүний нэр нь түг түмдийн ЭЗЭН” гэжээ (Иеремиа 10:10-16).

Бурхан бүтээсэн дэлхий ертөнцөө бүхэлд нь захирдаг. Түүнд хүссэн бүхнээ хийх хүч чадал бий. Исаиа 46:10-11 дээр Эзэн Өөрийн хүч чадлыг ийнхүү товч бөгөөд тодорхой дүрсэлсэн юм. Энэ нь:

“Зорилго минь хэрэгжинэ. Би тааламжит бүхнээ гүйцэтгэнэ гэсэн... Би айлдсан бөгөөд үүнийгээ Би гүйцэтгэнэ. Төлөвлөсөн бөгөөд заавал хийнэ” гэжээ (Исаиа 46:10-11).

Бурханы бүхнийг чаддаг мөн чанар итгэгч бидэнд энэ дэлхий эмх замбараагаа алдаж, уруудан доройтож байгаа мэт санагдах үед тийм биш гэдгийг сануулж өгдөг. Өөр ямар ч эх сурвалж, хүч чадал Бурханаас агуу байх боломжгүй. Энэ дэлхий ертөнц ямар ч байдалтай байсан Бурханы хяналтаас гарна гэж үгүй. Бурхан хэмжээлшгүй эрх мэдэлтэй бөгөөд Түүнийг хэзээ ч хүчин мөхөстөхгүй гэдэгт бид итгэлтэй байж болно. Энэ нь бидэнд хязгаарлагдмал оюун ухаанаараа ойлгох боломжгүй зүйлс дундуур итгэлээрээ алхах хүч чадлыг хайрладаг юм. Бид Бурханы харж байгаа бүхнийг харж чадахгүй байх үед Бурхан бүхнийг захирч байгаа, Түүнд хүссэн зүйлээ гүйцээхэд хүч хүрэхгүй зүйл байхгүй гэдгийг мэдэх нь үнэхээр сайхан. Надад юу ч тохиолдсон, амьдрал маань хаашаа ч эргэсэн, бүгд Бурханы энэрэлт мутрын эрх мэдэл дор байгаа шүү дээ. Тиймээс би өөрөө ч тайлбарлаж чадахааргүй тийм нөхцөл байдалд байсан ч Бурхан надтай хамт алхаж, тусалж дэмждэг гэдгийг мэдэх тул бат итгэлтэй байж чадна.

— Др. Роберт Ж. Листер

Бурхан хүч чадлаа үзүүлэн, ард түмнээ аварч байсан түүхүүд Библиэр дүүрэн байдаг. Бид Хуучин Гэрээний Гэтлэл номоос л гэхэд Бурхан Израилийг боолчлолоос чөлөөлөхийн тулд Египетэд тахал буулгасан тухай, ард түмнээ цөлд дөчин жилийн турш хоол хүнсээр таслаагүй болохыг, Амлагдсан нутгийг авахад нь тэдэнд ялалтыг өгсөн гэдгийг олонтоо уншдаг. Эртний Израильчуудын хувьд Гэтлэл ном бол тэдний мэдэх Бурханы золигч хүч чадлын талаарх хамгийн агуу жишээ байсан юм.

Бид Гэтлэл номд гардаг Бурханы хүч чадлын талаар Хуулийн номууд болох Гэтлэл 14:23, Тооллого 14:13, мөн Дэд Хууль 9:26-29 зэрэг эшлэлүүдээс харж болно. Энэ сэдвийн тухай Хуучин Гэрээний бусад хэсгүүдэд ч бас бий. Түүхтэй холбоотой номуудаас 2 Хаад 17:36, яруу найргийн номуудаас Дуулал 66:3-6, эш үзүүлэгийн номуудаас Исаиа 63:12 гэх мэт эшлэлүүдийг дурдаж болно.

Мэдээж эртний Израильчууд Эзэнд итгэх итгэлээрээ дамжуулан нигүүлслээр хүлээн авсан сүнслэг золилтынхоо агуу байдлыг үл тоосон гэсэн үг биш. Тэдний хувьд “Би итгэлээр ирэх Бурханы хүч чадалд итгэж байна” гэх нь туйлын үнэн зөв байсан. Гэхдээ “Бурхан манай үндэстнийг нэг л гараараа боолчлолоос чөлөөлснөөр

Өөрийн хүч чадлаа баталсан юм” гэж хэлэх нь Хуучин Гэрээг бичсэн олон хүмүүсийн хувьд илүү утга учиртай байсан юм. Мэдээж энэ бол нэг их гайхаад байх хэрэг биш л дээ. Гэтлэлийн үеэр Бурханы хүч чадлын гадаад илрэлүүд нь няцаахын аргагүй бодит байсан тул үл итгэгч Египетчүүд хүртэл итгэсэн байдаг.

Бурханы хязгааргүй хүч чадлын талаарх энэхүү ойлголттой холбоотойгоор бид Бурханы хязгааргүй хүч чадлаас үл хамааран Түүний *хийх боломжгүй* эсвэл *хийгүй* зүйлсийн тухай ярья. Юуны өмнө Тэрээр Эцэг хүний мөн чанараар бүхнийг хийдэг гэдгийг хэлэх нь зүйтэй. Тиймээс Тэрээр энэ мөн чанарынхаа эсрэг юм хэзээ ч хийхгүй гэсэн үг.

Мөн чанар гэдэг бол үндсэн ба хувийн шинж чанаруудын аль алиныг нь илэрхийлдэг өргөн утгатай хэллэг юм. Үүнийг бид хэн нэгний үндсэн зан чанар эсвэл оршихуйн чухал талууд гэж хэлж болох юм. Бурхан Эцэгийн хувьд Түүний мөн чанарт Түүний оршихуй, зан чанар багтахгаас гадна Гурвалын бусад гишүүдтэй харилцах харилцаа нь ч багтдаг. Эцэгийн мөн чанар хувиршгүй, өөрчлөгдөшгүй тул Түүний хүч чадлаа хэрэгжүүлэх арга нь ч үргэлж хэвээр байдаг. Бурханы мөн чанарын хувиршгүй байдлыг Иаков 1:17 дээр тайлбарласан байна. Энд:

“...гэрлүүдийн Эцэгээс бууж ирдэг. Түүнд өөрчлөлт ч, өөрчлөгдөх сүүдэр ч үгүй” гэжээ (Иаков 1:17).

Эцэг мөн чанартайгаа нийцэх зүйлсийг хийхэд хүч чадал нь хязгааргүй. Гэвч Тэр зөвхөн мөн чанартайгаа нийцэх арга замаар л хүч чадлаа хэрэгжүүлдэг. Жишээ нь, Тэр хэзээ ч үүрд мөнх байхаа болихгүй. Тэр хэзээ ч Хүү болон Ариун Сүнсний дээрх эрх мэдлээ цуцлахгүй. Тэр хэзээ ч гэм нүгэл үйлдэхгүй. Мөн тэр үргэлж амлалтаа биелүүлдэг.

Орчин үеийн шинжлэх ухааны хөгжилд нөлөөлсөн нэг хүчин зүйл бол Бурхан өнөөдөр ч өчигдрийнхтэй адил замаар ажилладаг гэдгийг таньж мэдсэн явдал байв. Энэ нь надад тун сонирхолтой санагдсан. Олон бурхан байдаг ба тэдгээр бурхад нь янз бүрийн амьгүй зүйлсэд оршдог гэсэн үзэл буюу анимизмын үзлийн дагуу хэрэв Бурхан тааварлашгүй юм бол бид энэ дэлхийг судлах аргагүй юм. Учир нь Бурханы арга зам өдөр бүр өөрчлөгдөнө гэсэн үг шүү дээ. Харин Бурхан өөрчлөгдөшгүй байвал бид энэ дэлхийг судалж, Түүний ажилладаг арга замуудыг судалж болно гэсэн үг. Тэгэхээр Бурхан хэзээ ч өөрчлөгдөшгүй гэдэг итгэл үнэмшил л өнөөгийн шинжлэх ухааны хөгжлийн гол суурь шүү дээ. Энэ нь өнөөгийн шинжлэх ухааныг хөгжих боломжийг олгосон шигээ, мөн таахын аргагүй нөхцөл байдалд орсон Христитгэгчдэд ч найдвар ба баталгааг өгдөг юм. Учир нь бидэнд учрыг нь олох шаардлага байхгүй. Бидэнд юу тохиолдох бол гэж санаа зовох хэрэггүй болно гэсэн үг. Харин бидний Бурханд хийж чадахгүй зүйл, давж чадахгүй бэрхшээл гэж үгүй гэдгийг мэдэж байхад л бидэнд хангалттай. Тэгээд Давид, Абрахам, Адам, Есүс болон Паулд амлаж, амлалтаа биелүүлсэн шигээ л Тэрээр нөхцөл байдалд тийнхүү хандана гэдгийг бид мэднэ. Тэр бол найдаж

**болохуйц, итгэмжтэй, нэг л янзаараа, өдөр бүр нэг л ижил байдаг.
Түүнд бидний бүхий л нөхцөл байдлыг шийдвэрлэх бүх хүч бий.**

— Др. Ш Ж. Лигон Дункан

Бид Эцэгийн хязгааргүй хүч чадлын тухай ярилцлаа. Одоо бүгдээрээ зөвхөн Бурханы бүхнийг чадагч, зүйрлэшгүй хүч чадлын тухай үзье.

Зүйрлэшгүй хүч чадал

Исаиа 14:24-27-р эшлэлд Бурханы хэнтэй ч зүйрлэшгүй хүч чадлыг хэрхэн тайлбарласныг сонсоцгооё. Энд:

“Түг түмдийн ЭЗЭН тангараглан “Үнэхээр бодсон хэрэг минь биелж, төлөвлөсөн минь бүтнэ. Би Ассирийг нутагтаа устган, уулан дээрээ гишгэнэ. Тохсон буулгыг нь хүмүүсээс авч, дарамтыг нь мөрнөөс нь зайлуулна. Энэ нь бүх дэлхийн талаар тогтоогдсон шийдвэр. Энэ нь бүх үндэстний дээгүүр сунгагдсан мутар юм. Учир нь түг түмдийн ЭЗЭН шийдсэн. Хэн түүнийг өөрчилж чадах вэ? Тэр мутраа далайсан. Хэн үүнийг буцааж чадах вэ?” гэв. (Исаиа 14:24-27).

Энэ багц эшлэлд Эзэний хязгааргүй хүч чадлын тухай дүрслээд, зөвхөн Түүнд л бүхнийг чадах хүч чадал бий гэснийг анзаарч байна уу. Түүнийг няцааж чадах хэн ч үгүй. Түүнийг өөрчилж чадах хэн ч үгүй.

Бурхан Эцэгийн хүч чадал хэнтэй ч зүйрлэшгүй гэдэг энэ ойлголт цорын ганц үнэн Бурхан байдаг гэдэг үнэнээс аяндаа урган гарсан юм. Мэдээж өөр үхэшгүй мөнхийн хүчтэй оршихуй байдаг байсан бол Бурханыг цорын ганц Бурхан гэхэд хэцүү байх байсан. Үхэшгүй мөнхийн хүчтэй байснаар эсвэл тэр хэмжээний хүч чадалтай байж л тэнгэрлэг бурхан болно шүү дээ.

Бурхан Иовд яг энэ тухай Иов номын 38-р бүлэгт л хэлсэн юм. Бурхан Иовд Өөр шиг нь энэ дэлхий ертөнцийг бүтээж, захирч, бүх зүйлийг хянах зэрэг агуу хүчирхэг зүйлсийг үйлдэж байж л өөрийгөө зөвтгөж болно гэж хэлсэн байдаг.

Гэтэл Бурхан бол цорын ганц үнэн, тэнгэрлэг Бурхан мөн. Тиймээс зөвхөн Бурхан л хязгааргүй хүч чадалтай.

Харамсалтай нь өнөө цагт олон олон сайн санаат Христитгэгчид Бурхан бүхнийг чаддаг гэдгийг үгүйсгэдэг болжээ. Тэд Библийг буруугаар ойлгож Бурхан бүтээлүүдийнхээ төлөө өөр хийж чадах зүйл үгүй гэж заадаг. Гэтэл Бурханы бүхнийг чадагч хүч чадал бол Бичвэрт буй гайхалтай бодит сургаал шүү дээ. Бурханы хүмүүс аюулд орсон үед Тэрээр тэдэнд тусалж чадна гэдгийг мэддэг учраас л тусламж эрэн гуйдаг. Энэ дэлхийд ёрын муу ноёрхож байгаа мэт санагдсан ч Бурхан ёрын муугаас илүү хүчтэй гэдгийг бид мэддэг учраас амар тайван байж чаддаг. Бурхан бол бүхнийг чадагч гэдэгт итгэхгүйгээр бид Бурхан дайснуудаа ялж, Өөрийн хүүхдүүдэд амласан ёсоор мөнхийн ерөөлийг өгнө гэдэгт итгэх үндэсгүй болно шүү дээ.

Төгс хүчит Эцэг гэдэг үгнээс баялаг их теологи хөврөн гардаг нь үнэхээр гайхалтай. Биднийг гайхамшигтайгаар хайрлан халамжилдаг Эцэгийн хайраар

дүүрэн, хүчирхэг, дотно Бурханд бид үйлчилдэг. Түүнд хийж чадахгүй зүйл байхгүй гэдгийг бид мэддэг учраас Түүний хамгаалалт бидний итгэлийг алдахгүй гэдэгт бид итгэлтэй байж чаддаг. Тэр үргэлж бидний Бүтээгч, Хаан бас өрхийн Тэргүүн байх болно. Түүний хүч чадал хязгааргүй бас зүйрлэшгүй. Тэр мөн Өөрөө хэзээ ч өөрчлөгдөхгүй учраас биднийг үргэлж авран хамгаалах болно. Түүний бидэнд өгдөг аврал ч бас үүрд мөнхийнх билээ.

Ингээд энэ хүртэл бид Гурвалын Бурхан, Гурвалын тэнгэрлэг бодгаль буюу бидний хэлж заншсанаар Төгс Хүчит Эцэгийн мөн чанарын тухай авч үзлээ. Тэгэхээр одоо гурав дахь сэдэв буюу Эцэгийн бас нэг үүрэг болох тэнгэр газрыг Бүтээгч Нэгэн гэдгийг үзэхэд бэлэн боллоо.

БҮТЭЭГЧ

Тэнгэр газрыг Бүтээгч Эцэгийн тухай ярихдаа бид Түүний бүтээлч үйлсийг гурван талаас нь авч үзэх болно. Нэгдүгээрт, бид Эцэгийн бүтээлийн үйлсийн тухай суралцана. Хоёрдугаарт, Түүний бүтээлийн сайн сайхан байдлыг анхаарч үзнэ. Гуравдугаарт, Эцэгийн бүтээлүүдийнхээ дээрх эрх мэдлийн тухай тус тус үзэх болно. Ингээд эхлээд Эцэгийн бүтээсэн бүтээлийн үйлсийг тунгаан бодоцгооё.

БҮТЭЭЛ

Бүтээл бол *Элч нарын тунхагт* Эцэгийн тухай онцлон хэлсэн нэг ажил нь юм. Энэ нь итгэлийн үндсэн тунхаглалын хамгийн эхний хэсэгт багтсан болохыг та санаж байгаа байх. Энэ нь:

**Би тэнгэр газрыг Бүтээгч
Төгс Хүчит Бурхан Эцэгт итгэдэг.**

Энэ бол Бичвэр дэх Бурханы хийсэн бүх зүйлсээс Христитгэлийн түүхэнд итгэгч бүрийн хүлээн зөвшөөрдөг Бурханы хийсэн нэг ажил юм.

Ихэнх Христитгэгчид Бурхан дэлхий ертөнцийг бүтээж, тэтгэж байдаг гэдгийг мэддэг. Учир нь Бичвэр энэ тухай олонтоо өгүүлдэг. Үнэндээ бид Библийн хамгийн эхний хуудсыг нээн уншихад л Бурханыг тэнгэр газрыг Бүтээгч гэснийг олж хардаг. Эхлэл 1:1-р эшлэлийн харцгаая. Энэ нь:

“Эхэнд Бурхан тэнгэр газрыг бүтээжээ” гэдэг (Эхлэл 1:1).

Энэхүү танилцуулга эшлэлийн дараа Эхлэл номын 1-р бүлгийн үлдсэн хэсэгт Бурхан зургаан өдрийн дотор дэлхий ертөнцийг бүтээж, байрлуулсан тухай тайлбарласан байдаг.

Чуулганы түүхийн туршид Эхлэл 1-р бүлгийн тайлбарын талаар олон янзын онол бий болсоор ирсэн. Бараг бүх теологичид Бурхан *экс нихило* буюу оргүй

хоосноос орчлон ертөнцийг бүтээсэн гэдэг дээр санал нийлдэг. Энэ нь Бурхан тэнгэр газрыг бүтээхээс өмнө Түүнээс өөр юу ч үгүй байсан гэсэн үг юм. Бурхан өмнө нь оршин байсан ямар нэг зүйлээр дэлхий ертөнцийг бүтээгээгүй. Түүгээр ч зогсохгүй Бурхан цаг хугацаа болон орон зайг бүтээсэн гэдэг дээр олон хүн санал нийлдэг.

Харин теологичид Бурхан Эцэг энэ дэлхий ертөнцийг яг хэрхэн бүтээсэн талаар, ялангуяа, бүтээлийн зургаан өдрийн мөн чанарын тухай санал зөрөлддөг. Клемент, Орижен, Августин зэрэг чуулганы эцгүүд эдгээр өдрүүд бол бүтээл нь нэг агшинд бий болсныг төлөөлсөн дүрслэл гэж үзсэн. Харин Иренеус, Тертуллиан гэх мэт хүмүүс үүнийг энгийн 24 цагийн хугацааг илэрхийлсэн гэдэг. Гэтэл шинжлэх ухаан дэлхий ертөнцийг олон жилийн настай гэж үзэж эхэлснээс хойш олон теологичид бүтээлийн хугацааны тухай өөрөөр тайлбарлаж эхэлсэн. Зарим нь өдөр гэдэг нь 24 цагийг хэлсэн хэдий ч Бурханы бүтээлийн өдрүүдийн хооронд урт хугацаа байсан гэж үзсэн. Харин бусад нь өдөр гэдгийг эрин үе ба эрин зууны дүрслэл гэж үзэх болсон.

Эхлэл 1-р бүлэг дэх бүтээлийн өдрүүдийн талаарх асуудал нь олон янзын маргааны үндэс болсон нь мэдээж. Тэдгээр маргааны нэг бол энэ нь утга зохиолын ямар хэлбэртэй вэ? гэдэг асуудал гэж бичсөн байна. Жинхэнэ үнэн баримтыг ойлгуулахын тулд бичсэн үү? Эсвэл сүнслэг үнэнийг тайлбарлахын тулд бичсэн үү? Тэгэхээр бид аль ч талд нь орж болохгүй юм. Бурхан бол дэлхий ертөнцийн Бүтээгч. Энэ үнэн дээр л бид санал нийлэх ёстой. Эхлэл 1-р бүлгийг шинжлэх ухааны баримт гэж уншвал мэдээж бүтээлийн утга учир, мөн чанарыг мэдэх гэж уншихаас огт өөрөөр тайлбарлах хэрэгтэй болно шүү дээ.

— Др. Жон Освалт

Анхны чуулган болон итгэгчдийн *Элч нарын тунхгийг* ашиглаж байсан хамгийн чухал зорилго бол итгэгчдэд Бурхан, зөвхөн Бурхан Эцэгийн бодгалиар удирдуулсан Бурхан л энэ дэлхий ертөнцийн сүнслэг, материаллаг, амьд ба амьгүй бүхнийг бүхэлд нь бүтээж, тогтоон тэтгэж байдаг гэдгийг ойлгуулах явдал байсан юм.

Энэ нь Нехемиа 9:6 дээрх Левитчүүдийн хэлсэн санаатай нийцэж байгаа юм. Тэдний үгийг сонсоцгооё. Энэ нь:

“Өө, ЭЗЭН минь, Та л ганц ЭЗЭН билээ. Тэнгэр болон тэнгэрсийн тэнгэрийг түг түмдтэй нь, газар ба түүн дээрх бүхнийг, тэнгис төдийгүй түүний доторх бүхнийг бүтээсэн нь Та билээ. Тэр бүхнийг амилуулсан нь Та билээ. Тэнгэрийн түг түмдийг өмнөө мөргүүлэгч нь Та билээ” гэжээ (Нехемиа 9:6).

Энд Бурхан ганцаараа энэ дэлхий ертөнцийг бүтээсэн гэж хэлсэн байна. Мөн зөвхөн Бурхан л оршин буй бүхэнд амь өгөгч, бүтээсэн дэлхий ертөнцийг тогтоон тэтгэгч нь юм гэжээ.

Мэдээж тэнгэр газрыг бүтээж, тохинуулах ажлыг Бурхан Эцэг удирдан

хийсэн боловч энэ ажилд Гурвал бүхэлдээ өөр өөр арга замаар оролцсон гэдгийг онцлон хэлэх нь зүйтэй. Жишээ нь, Эцэг Хүүг энэ дэлхий ертөнцийг бүтээхдээ ашигласан байдаг. Тэр одоо ч дэлхийг тогтоон тэтгэхэд оролцдог.

Бүтээлийн тухай 1 Коринт 8:6 дээр Паул юу гэж тайлбарласныг сонсоцгооё. Энэ нь:

“Бидний хувьд ганц Бурхан Эцэг байна. Бүх юм Түүнээс гарсан бөгөөд бид Түүний төлөө юм. Мөн ганц Эзэн Есүс Христ байна. Бүх юм Түүгээр агаад бид ч Түүгээр байгаа юм” гэжээ (1 Коринт 8:6).

Энд Бурхан Эцэг бол бүтээлийн эх үндэс гэж Паул хэлсэн байна. Бүтээл *Түүнээс* бий болсон. Харин ингэхдээ энэ нь Хүүгээр *дамжуулан* бий болсон. Эцэг Хүүгээрээ дамжуулан амьдралыг тогтоон тэтгэсээр байгаа учраас л бид амьдарсаар байгаа юм гэжээ.

Ариун Сүнсний оролцоо Бичвэрт арай далд хэлбэрээр дурдагдсан байдаг. Хуучин Гэрээнд голдуу Бурханы Сүнсний ажлуудын талаарх эшлэлүүдэд дурдагддаг. Хуучин Гэрээний үед Ариун Сүнс Бурханы нэг бодгаль гэж хараахан бүрэн илчлэгдээгүй байсан ч гэсэн энэ дэлхийд Бурханы хүслийг биелүүлсээр ирсэн. Ариун Сүнс Хуучин Гэрээг бичсэн хүмүүсийг онгодоор хөтөлсөн тухай Марк 12:36 дээр бий. Хуучин Гэрээний үед ч эш үзүүлэг ба сүнслэг бэлэг авьяасын эх үндэс бол Ариун Сүнс байсан гэж Паул Үйлс 2:2-17-д хэлсэн байдаг.

Хуучин Гэрээнд Бурханы Сүнсний тухай бичихдээ Ариун Сүнс бол бие даасан тэнгэрлэг бодгаль гэдэг хожмын, илүү тодорхой илчлэлийг таамаг төдийгөөр үлдээсэн нь учиртай. Жишээ нь, Эхлэл 1:2-3 дээр энэ тухай өгүүлдэг. Энэ нь:

“Газар нь хэлбэржээгүй, хоосон төдийгүй оёоргүй гүнийв гадаргууд харанхуй бүрхэж, Бурханы Сүнс усны мандал дээгүүр элин хальж байлаа. Тэгэхэд Бурхан —Гэрэл бий болтугай! гэж айлдсанд гэрэл бий болов” гэжээ (Эхлэл 1:2-3).

Энд буй “Бурханы Сүнс” гэдэг нь Бурханы бүх бодгалиудыг хэлж байна. Гэхдээ Шинэ Гэрээний зүгээс харах юм бол энд Ариун Сүнсний бодгалийн ажлыг онцолсон байна гэж харж болно.

Бид Бурхан Эцэгийн Бүтээгч үүргийнх нь тухай авч үзлээ. Одоо бүгдээрээ бүтээлийн сайн сайхны тухай үзэхэд бэлэн боллоо.

БҮТЭЭЛИЙН САЙН САЙХАН

Ихэнх шашин бас философи материаллаг ертөнц бол ёс бус буюу сайн ч биш, муу ч биш гэж үздэг. Зарим нь энэ дэлхий бол ёрын муу гэж хэлдэг. Жишээ нь, анхны чуулганд тулгараад байсан тэрс үзлийн философи нь материаллаг ертөнц завхарсан тул үнэн авралд хүрэхийн тулд энэ бие махбодоосоо чөлөөлөгдөх ёстой гэж үздэг байжээ. Дэлхий ертөнцийн тухай энэ сөрөг үзэл бол Бурхан тэнгэр газрыг бүтээсэн гэдгийг *Элч нарын тунхагт* онцлон заах нэг шалтгаан болсон юм. Дэлхий ертөнц бол Бурханы сайн сайхан чанар шингэсэн, сайн сайхан бүтээл хэмээн Библид хэлсэн

байдаг.

Эхлэл 1-р бүлгийн 4, 10, 12, 18, 21, 25 мөн 31-р эшлэлүүдэд бүтээлийн сайн сайхны тухай нийтдээ долоон удаа дурдсан байдаг. Тэгээд тэдгээрийн хамгийн сүүлд нь Бичвэр хэлэхдээ бүтээл бүхэлдээ зүгээр нэг “сайн” биш, харин “нэн сайн” болсон гэжээ. Эхлэл 1:31 дээр Мосе юу гэж хэлснийг харцгаая. Энд:

“Өөрийнх нь буй болгосон бүгд нэн сайн болсныг Бурхан харлаа” гэж (Эхлэл 1:31).

Харамсалтай нь, Бурхан энэ дэлхийг бүтээгээд удаагүй байхад Адам Ева хоёр сайн мууг мэдүүлэгч модны жимснээс идэж, Бурханы эсрэг гэм нүгэл үйлдсэн юм. Хүн төрөлхтний энэхүү гэм нүглээс болж Бурхан бүтээлийг бүхэлд нь хараасан юм. Үүний тухай Эхлэл 3:17-19 дээр Бурхан Адамд хандан хэлсэн байдаг. Энэ нь:

“Чамаас болж газар хараагдлаа. Чи амьдралынхаа бүхий л өдрүүдэд бэрхшээл зүдүүр дунд түүнээс хооллох болно. Чамд тэрээр өргөс зангууг ч ургуулна. Чи хээрийн өвс ногоог ч идэх болно. Чи газар шороондоо буцталаа духныхаа хөлсийг дуслуулан байж хоолоо олж иднэ” гэжээ (Эхлэл 3:17-19).

Бурхан Адамын гэм нүглээс болж газар шороог хараасан тул тариа ногоо ургах нь амаргүй болж, Адам болон бусад хүн төрөлхтөн хоолныхоо төлөө хөлсөө дуслуулах хэрэгтэй болсон. Газар шороог хараасан энэ хараал газар тариаланд төдийгүй дэлхийн бүхий л зүйлст нөлөөлсөн. Паул Есүс Христээр дамжин ирэх итгэгчдийн аврал нь эцэстээ бүтээлийг эргэн сэргээх болно хэмээн Ром 8-р бүлэгт бичсэн байдаг. Ром 8:20-22 дээрх Паулын үгийг сонсоцгооё. Энд:

“Яагаад гэвэл бүтээл...хоосонд захирагдсан боловч найдвар дотор бүтээл өөрөө ч мөн ялзралын боолчлолоос чөлөөлөгдөж...өнөөг хүртэл бүх бүтээл нь хамтдаа ёолон, хамтдаа төрөх зовлон эдэлдгийг бид мэднэ” гэжээ (Ром 8:20-22).

Газар шороонд хүрсэн хараал нь бүхий л бүтээлд нөлөөлсөн гэж Паул энд хэлсэн байна.

Хэдий Бурхан ийнхүү хараасан ч бид бүтээл нь сайн сайхан байхаа больсон гэж бодож бодохгүй юм. Тийм ээ, хүн төрөлхтөн гэм нүгэлд унаснаас болж бүтээл хохирол амссан. Гэсэн ч дэлхий ертөнц одоо ч Бурханы хэвээрээ тул үг үндэс нь сайн сайхан хэвээрээ билээ. Паул гэрлэлтийн хүчинтэй байдлын тухай мөн Христитгэгчид бүхий л хоол хүнсийг идэж болох тухай бичихдээ мөн энэ тухай дурдсан байдаг. 1 Тимот 4:4 дээр тэрээр хэлэхдээ:

“Бурханы бүтээл бүр сайн” гэжээ (1 Тимот 4:4).

Паулын хэлсэн үгийг анзаарав уу. Тэр бүх бүтээл сайн “байсан” гэж хэлээгүй. Харин Бурханы бүтээл бүр сайн “байна” гэж хэлжээ.

Үнэндээ энэ бодит дэлхий ертөнц бол сайн сайхан юм. Учир нь Бурхан үүнийг сайн гэж тунхагласан. Энэ нь бидний амьдралд олон бодит нөлөөтэй. Үүний нэг нь бид байгаль орчноо хамгаалах хэрэгтэй гэдэг явдал юм. Бид бол бүтээлийг хариуцсан нярвууд. Мөн Бурхан ч энэхүү бүтээлээ хайрлан хамгаалах болно. Тэр дахин сэргээх болно. Бүтээл устаж алга болохгүй. Харин дахин сэргэх цаг ирнэ. Бид шинэ тэнгэр, шинэ газарт үүрд мөнх амьдрах болно. Бурханы бүтээсэн энэ бодит дэлхий ертөнц бол сайн сайхан юм. Бидний бие махбод хийгээд бидний эргэн тойрон бүгд сайн сайхан юм шүү дээ.

— Др. Марк Л. Страус

Тэгэхээр гэрлэлт, хоол хүнс гээд Бурханы бүтээсэн бүхэн сайн гэдэгт бид итгэлтэй байж болно гэсэн үг. Паул Ром 1-р бүлэгт Бурханы сайн сайхан нь бүтээлүүдээр дамжин хүн төрөлхтөнд илэрхий харагддаг гэж хэлсэн нь ийм учиртай. Мөн Дуулал 19-д *тэнгэрс Бурханы суу алдрыг тунхаглаж байна* гэж хэлсэн нь ч бас ийм учиртай..

Жон Весли арван наймдугаар зуунд бичсэн *Бүтээл дэх Бурханы мэргэн ухааны судалгаа (A Survey of the Wisdom of God in the Creation)* номынхоо 3-р хэсгийн, 2-р бүлэгт бүтээлийн сайн сайхны тухай дүрсэлсэн байдаг. Түүнийг юу гэж бичсэнийг сонсьё. Энд:

“Дэлхий ертөнц бүхэлдээ Дээд Нэгэний төгс төгөлдөр байдлыг илтгэсэн зураг юм. Энэ зураг нь Түүний оршихуйгаас гадна Түүний нэгдэл, хүч чадал, мэргэн ухаан, бие даасан байдал, сайн сайхныг харуулдаг” гэжээ.

Дэлхий ертөнц бол сайн Бурханы бүтээл учраас аль хэдийн өөртөө агуулж буй төрөлх сайн сайхнаараа дамжуулан Түүний сайн сайхныг харуулдаг.

Бурханы бүтээл бол Түүний сайн сайхны тусгал юм. Үүнээс бид юуны өмнө бүтээл өөрөө ёрын муу биш бөгөөд ёрын муу угаасаа бүтээлтэй хамаагүй байсан гэдгийг харж болно. Мөн Бурхан энэ дэлхийг бүтээхдээ үнэхээр сайн сайхнаар бүтээсэн гэдгийг ч харж болно. Бүтээл угаас гоо үзэсгэлэнтэй. Гэхдээ тэрхүү гоо үзэсгэлэн гэм нүглийн үр дагавраас болж сэвтсэн юм. Өргөс, зангуу, духны хөлс урсах гээд л, Бурханы бүтээл доройтсон. Гэхдээ Христитгэгчдийн хувьд биднийг эргэн сэргээх үйл явцыг Бурхан аль хэдийн бидний дотор эхлүүлсэн. Бид бол Христийн доторх шинэ бүтээл мөн. Эртний нэгэн магтан дуунд өгүүлснээр *Христгүй хүмүүсийн нүд хэзээ ч харж байгаагүй тэр л зүйлсийг Христитгэгчид хардаг* гэжээ. Бид бүтээлийг Бурханы мутрын бүтээл гэдгийг ойлгож эхэлдэг. Түүнчлэн бид бүтээл доторх урлаг, гоо үзэсгэлэн, бүтэц, зохицол, нэгдлийг олж хардаг. Энэ бол шинэ тэнгэр газрын амталгаа юм. Өөрөөр хэлбэл Бурханы бүтээлүүд бүхэлдээ шинэчлэгдэх үед биднийг бүтээлийн сайханд баясан

баярлуулахыг хүссэн яг л тэр зорилго биелж, бид тийнхүү баясах баярлах болно.

— Др. Дерек Томас

Ингээд бид бүтээл болон бүтээлийн сайн сайхны тухай ойлголттой боллоо. Одоо бүгдээрээ Эцэг Өөрөө Бүтээгчийнхээ хувьд бүтээлийнхээ дээгүүр эрх мэдэлтэй байдаг тухай авч үзье.

БҮТЭЭЛИЙН ДЭЭРХ ЭРХ МЭДЭЛ

Эцэгийн бүтээгчийн эрх мэдлийн тухай ярих зүйл олон бий. Гэхдээ бид үндсэн гурван шинж чанарыг нь авч үзэх болно. Эдгээр нь Түүний эрх мэдэл бол бүрэн эрхт, хосгүй онцгой, бүхнийг хамарсан байдаг. Энэ гурван шинж чанарын тухай нэг бүрчлэн ярилцъя. Эхлээд Бүтээгч Эцэгийн эрх мэдлийн бүрэн эрхт мөн чанарын тухай авч үзье.

Бүрэн эрхт эрх мэдэл

Өөрийн бүтээлээ яах эсэхээ шийдэх бүрэн эрх чөлөөтэй тул Эцэгийн эрх мэдэл бол бүрэн эрхт юм. Библид Түүний бүрэн эрхт эрх мэдлийг ихэвчлэн ваарчин шаврынхаа дээгүүр эрх мэдэлтэй байдагтай зүйрлэдэг. Бид энэ тухай Исаиа 29:16, Исаиа 45:9, Иеремиа 18:1-10, мөн Ром 9:18-24 зэрэг эшлэлүүдээс харж болно. Бурханы эрх мэдлийн тухай Паул Ром 9:20-21 дээр юу гэж хэлснийг хамтдаа сонсоцгооё. Энд:

“Баримал нь “Та яагаад намайг ингэж хийв?” гэж барималчинд хэлдэг үү? Нэг зуурмагийн шавраар хүндэтгэлийн нэг сав, ердийн хэрэглээний өөр нэг савыг хийхийн тулд ваарчин шаврынхаа дээр эрх мэдэлгүй гэж үү?” гэжээ (Ром 9:20-21).

Мэдээж Паулын уран яруу асуултын хариулт нь ойлгомжтой. Бурхан бол бүхнийг Бүтээгч учраас бүтээсэн бүхэндээ юу хүссэнээ хийх эрх чөлөө, эрх мэдэл Түүнд бий.

Бурхан энэ дэлхий дээр болж байгаа бүх зүйлсийн дээгүүр бүрэн дээд эрх мэдэлтэй гэж Библид заасныг зарим хүмүүс сонсоод айж түгшин, эгдүүцэн бухимдаж ч болох юм. Харин Христитгэгчид Бурханыг хэн бэ гэдгийг мэддэг болохоор талархалтай байх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл бидний амь амьдрал бидний төлөө Өөрийн хүүгээ загалмай дээр өгсөн бүх мэргэн ухаан, бүх хүч чадал болон хайр нигүүлслээр дүүрэн Эцэгийн гарт байгаа. Ялангуяа, зовлон бэрхшээлтэй үед, амьдрал хяналтаас гарах үед энэ бол жинхэнэ гайхалтай тайвшрал болдог.

— Др. Деннис Э. Жонсон

Хэдийгээр бид амьдралд минь болж байгаа зүйлсийг ойлгохгүй байж болох ч хэрэв та Есүс Христэд итгэсэн бол Бурхан таны аав бөгөөд таныг хайрлан халамжилж байдаг. Тэрээр таныг ямар ч зүйл туулсан хамгаалж, харж ханддаг. Заримдаа бид асар их зовлон шаналлыг туулдаг. Гэхдээ бүх зүйл Түүний хяналтад бий. Тэрээр таны сайн сайхны төлөө, таны ариуслын төлөө үүнийг зөвшөөрсөн гэдгийг та амьдралдаа хүлээн авч чадах уу?. Бурхан дайснуудыг маань анд нөхөд болгон эргүүлдэг. Ингэж л биднийг хайрладаг Түүгээр дамжуулан бид давуулан дийлдэг. Бид зүгээр нэг ялан дийлдэггүй. Биднийг хайрладаг Түүгээр дамжуулан бүр давуулан дийлдэг гэж байна. Тэгэхээр Бурхан биднийг ариусгаж, Есүстэй адилхан болгохын тулд зовлон бэрхшээлийг ашигладаг. Тэр л зөвшөөрсөн учраас бидний амьдралд энэ бүхэн тохиолдож, бид Христтэй адил болж чадна. Тэр ухаалаг сайн эцэг шиг биднийг сахилгажуулдаг хэмээн Еврей 12-р бүлэгт өгүүлсэн байдаг. Итгэлийн тэмцлийн утга учир бол энэ гэж би бодож байна. Би ойлгохгүй байсан ч Бурхан надад санаа тавьдаг гэдгийг өөртөө байн байн сануулж байх хэрэгтэй. Тэрээр энэ бүгдийг миний сайн сайхан, ариун байдал, ариуслын төлөө л үүнийг зөвшөөрсөн байдаг.

— Др. Томас Р. Шрайнер

Хосгүй онцгой эрх мэдэл

Бурхан эцэг бүрэн эрхт эрх мэдэлтэйгээс гадна бүтээсэн бүхнийхээ дээр хосгүй онцгой эрх мэдэлтэй. Эцэгийн бүтээгчийн эрх мэдэл хосгүй онцгой гэдэг нь өөр хэн ч түүн шиг бүрэн эрхт биш учраас л тэр юм. Зөвхөн бүтээгч л бүрэн эрхт эрх мэдэлтэй. Зөвхөн Бурхан л бүтээгч юм. Үүнээс гадна Гурвалын экономик буюу зохион байгуулалтын хувьд Эцэг Гурвалын бусад бодгалиудынхаа дээгүүр эрх мэдэлтэй байдаг. Жишээ нь, Есүс энэ тухай Иохан 5:26-27 дээр өгүүлдэг. Энд:

“Эцэгт Өөрт нь амь байдгийн адил мөн Хүүд Өөрт нь амь байлгахыг Хүүдээ Тэр соёрхжээ. Тэр бол Хүний Хүү тул шүүлтийг гүйцэтгэх эрх мэдлийг Тэр Түүнд өгөв” гэжээ (Иохан 5:26-27).

Есүс энэ дэлхийг шүүх эрх мэдлээ Эцэгээсээ авсан гэж энд хэлсэн байна. Энэ эрх мэдэл эцсийн эцэст Эцэгт байдаг. Мөн Түүний энэ эрх мэдэл хосгүй онцгой эрх дарх байсан. Гэтэл Эцэг Өөрийнхөө өмнөөс дэлхийг шүүлгэхээр Хүүгээ томилжээ. Үүнтэй ижил санааг 1 Коринт 15:24 дээрээс харж болно. Энд Есүсийн дэлхий ертөнц дээрх эрх мэдэл нь Эцэгийн агуу хаанчлалын дор байдаг гэжээ.

Ариун Сүнсний хувьд ч бас адил. Иохан 16:13, Ром 8:11 болон 1 Петр 1:2

зэрэг эшлэлүүдэд Ариун Сүнс ч мөн Эцэгийн хүслийг биелүүлдэг гэжээ.

Хүүгийн эрх мэдэл болон Ариун Сүнсний эрх мэдлийг Эцэг өгдөгчлөн бусад бүх л бүтээлийн эрх мэдлийг Эцэг өгдөг. Тэнгэр элч нар, дэлхийн удирдагчид, эгэл хүмүүст хүртэл тодорхой хэмжээний эрх мэдэл бий. Энэ бүх эрх мэдлүүдийг Бурхан өгдөг. Тиймээс Эцэгийн эрх мэдэл бүтээлийн эрх мэдлээс ямагт дээгүүр байдаг гэсэн үг.

Бүхнийг хамарсан эрх мэдэл

Эцэгийн эрх мэдэл бүрэн эрхт, хосгүй онцгой байдгаас гадна Түүний дэлхий ертөнцийн дээгүүрх эрх мэдэл нь *бүхнийг хамарсан* байдаг. Бурханы эрх мэдэл бүхнийг хамарсан гэдэг нь тэр бүтээсэн бүхнээ нэг бүрчлэн захирдаг гэсэн үг. Энэ нь хоёр чухал утгыг илэрхийлдэг. Нэгдүгээрт, *хүн бүр* Бурханы эрх мэдэл дор байдаг гэсэн үг. Бурханыг дуулгавартай байх үүргээс ангид байх хэн ч, ямар ч оршихуй байхгүй.

Эцэгт үнэнч тэнгэр элч нар болон хүмүүс Түүнийг хүлээн зөвшөөрч, дуртайяа захирагддаг. Харин чөтгөрүүд, итгэлгүй хүмүүс Түүнийг эсэргүүцэн тушаалуудыг нь сахихаас татгалздаг. Гэсэн хэдий ч Эцэгийн ёс суртахууны шүүлт хүн бүрд тулгарах болно. Бид хаана амьдарч, ямар шашин соёлтой байхаас үл хамааран бүгд Бурханы өмнө хариуцлагатай.

Хоёрдугаарт, *бүх зүйлс* Бурханы эрх мэдэл дор байдаг. Түүний эрх мэдэл бүтээсэн зүйлсийнх нь бүхий л хэсгүүдийг хамардаг. Учир нь Бурхан бүхнийг бүтээсэн бөгөөд бүгд тодорхой ёс суртахуунтай байдаг. Тэр бүх зүйлийг зорилготой мөн ёс суртахууны чанартай байхаар бүтээсэн. Өөрөөр хэлбэл юу ч байсан, ямар ч бүтээл байсан зорилгогүй эсвэл ёс суртахууны хувьд тодорхойгүй бүтээгддэггүй. Бүтээл бүр Бурханы хүслийн дагуу ажилладаг тул сайн байдаг, эсвэл Түүнийг эсэргүүцэн босдог тул ёр муу байдаг.

Орчин цагт итгэгчид амьдралын асуудлуудыг ариун зүйлс, дэлхийн зүйлс гэж ангилан хуваах хандлагатай болсон. Бурханы эрх мэдэл доорх “Ариун” зүйлсэд сүм чуулган, магтаал хүндлэл, Сайнмэдээ мөн Библи судлал зэргийг багтаадаг гэж ойлгодог. Мөн бид гэр бүл, ёс зүйн холбоотой шийдвэрүүд дээрээ Бурханы тушаалуудыг сахихыг эрмэлзэж, үүнийгээ ариун зүйл хийж байна гэж боддог. Гэтэл улс төр, боловсрол, ажил мэргэжил гэх мэт “дэлхийн” зүйлсэд Бурханы тушаалууд хамаагүй гэж боддог Христитгэгчид олон байдаг. Орчин цагийн энэ *ариун* болон *дэлхийн* гэж ялгадаг явдал нь үнэндээ Библийн дагуу биш юм. Сургаалт үгс 3:6, Номлогчийн үгс 12:14, мөн 2 Тимот 3:16-17 зэрэг эшлэлүүдэд Бурхан хүний амьдралын бүхий л талбаруудын тухай өгүүлсэн байдаг бөгөөд Түүний эрх мэдэл бидний хийдэг бүх зүйлд хамаатай гэдгийг харуулдаг.

Бид эрх мэдлийг ихэнхдээ сөргөөр ойлгодог дэлхийд амьдарч байна. Тиймээс Христитгэгчид Бурханы эрх мэдэлд итгэх нь гайхалтай хэрэг юм. Учир нь Бурхан энэ дэлхийг одоо ч хайрласаар байна. Бүх зүйл Бурханы хяналтад бий. Бурхан эхлэлээс төгсгөл хүртэлх бүхнийг мэддэг. Бурхан бол бүх хүнийг шүүх тэр Нэгэн мөн. Тэр юу хийхээ сайн мэддэг учраас бид

итгэлтэй байж болно. Энэ бол бидний ирээдүйн найдвар юм.

— Др. Симон Виберт

ДҮГНЭЛТ

Бурхан Эцэгийн тухай энэ хичээлээрээ бид *Элч нарын тунхгийн* хамгийн эхний итгэлийн үндсэн тунхаглалыг нарийвчлан авч үзлээ. Бид энэхүү тунхаглал дахь Бурханы талаарх ойлголтыг ярилцлаа. Бид Төгс Хүчит Бурхан Эцэгийг Гурвалын эхний бодгаль гэдгийг үзсэн. Мөн Эцэгийн тэнгэр газрыг Бүтээгч үүргийнх нь тухай судаллаа.

Бурхан Эцэгийн бодгалийн тухай ойлголт нь Христитгэлийн бүх теологийн үндэс суурь юм. Бичвэр дэх Гурвалаар оршигч жинхэнэ Бурханыг таньж итгэхгүй л юм бол бид хуурамч бурхныг шүтэж байгаагаас өөрцгүй болно. Тэгэхээр Бичвэрт Эцэг гэж нэрлэсэн Гурвалын бодгалийг таньж мэдэж, итгэн хүндлэх нь жинхэнэ мөргөл хүндлэлийн чухал хэсэг юм. Хүү болон Ариун Сүнс хоёулаа Эцэгийг дуулгавартай даган, хүндлэн мөргөдөг бөгөөд тэд Эцэгийн алдрын төлөө ажилладаг. Тиймээс Бурхан бол бидний дуулгавартай байдал, хүндлэл мөргөл, алдар магтаалын төв нь билээ.

ХАМТРАГЧИД

Др. Ван Гэйтон (хөтлөгч) бол Виллиамс Библийн Институтийн салбарын захирал, дэрхий даяарх өөр олон сургалт болон их сургуулиудад Библийн багш, илтгэгч. Др.Гэйтон нь мөн Холбооны Шоронгийн товчооны эрхлэгчээр 4 жил үйлчилсэн. Мөн Вашингтоны Шашин ба Олон нийтийн бодлогын институтийн захирлуудын зөвлөлд байсан. Др.Гэйтон нь Олон улсын Семинар сургуулийн Теологийн мастер, Логос Библийн Коллежоос Шашны мастер, Христитгэлийн Удирдлагын Их Сургуулийн Библийн философийн доктор, Фэйт теологийн семинарийн Теологийн доктор, Реформэд теологийн семинарын Үйлчлэлийн доктор зэргийг тус тус хамгаалжээ. Мөн тэрээр Апостолик Саксэшинд бишопоор томилогдож байсан. Христийн Биеийн түүхэн нэгдлийг сэргээх зорилготой Христитгэлийн чуулгануудын Олон улсын Коммунитигийн тэргүүн бишопоор үйлчилж байсан.

Др. Дэвид Р. Бауэр бол Библийн орчуулгын Сургуулийн салбарын захирал ба Асбури Теологийн Семинарын Индактив Библийн судлалын Ралф Валдо Бийсон Профессор.

Др. Стив Блейкмор бол Вэсли Библийн Семинарын философийн туслах Профессор.

Др. Паул Чанг бол Нью Жерсигийн Монмауф Хятадын Христитгэлийн Чуулганы Ахлах пастор.

Др. Ж. Лигон Дункан III бол Реформэд теологийн семинарын Канселлор, СЕО ба Системт болон Түүхийн Теологийн Жон И. Ричардсийн Профессор.

Др. Матт Фрайдеман бол Весли Библийн Семинарийн Сайнмэдээ тараах болон Дагалдуулалтын профессор.

Др. Стив Харпер бол Флорида мужийн Орландо дахь Асбури Теологийн Семинарийн Флорида -Дуннам кампусыг үүсгэн байгуулагч, дэд Ерөнхийлөгч. Сүнслэг байгуулалт болон Весли судлалын тэтгэвэрт гарсан профессор.

Др. Деннис Э. Жонсон бол Калифорнийн Вэстминстер Семинарийн Практик теологийн гавьяат профессор.

Др. Кэйт Жонсон Круд (өмнө нь Христийн төлөөх Кампус Крусэйд байсан) Теологийн боловсролын Үндэсний Удирдагч бас Шинэчлэгдсэн теологийн семинарын Системт теологийн зочин профессор.

Др. Риад Кассис бол Эвангелийн Теологийн Боловсролын Олон Улсын зөвлөлийн Олон улсын захирал.

Др. Самуэл Линг бол Хятад Хоризоны хамтран үүсгэн байгуулагч.

Др. Роберт Ж. Листер бол Теологийн Талбот Сургуулийн Библийн болон Теологийн судлалын туслах профессор.

Др. Жон Освалт бол Асбури теологийн семинарын Хуучин Гэрээний хүндэт зочин профессор.

Др. Ж. И. Пакер (1926-2020) нь Британийн Колимб, Ванкуверын Режент Коллежийн Говернорс Зөвлөлийн профессор агсан ба Их Британи болон Америкт алдартай номлогч, илтгэгч байсан.

Др. Ричард Л. Прагт, Жр. Бол Гуравдахь мянган үйлчлэлийн хамтран үүсгэн байгуулагч ба Ерөнхийлөгч.

Др. Томас Р. Шрайнер бол Жэймс Буханан Харрисоны Шинэ Гэрээний орчуулгын профессор ба Өмнөд Баптист Теологийн Семинарт Бичвэр ба орчуулгын эрхлэгч

Др. Марк Л. Страусс бол Сан Диаго дахь Бетел Семинарын Шинэ Гэрээний профессор.

Др. Дерек Томас бол Жоржиа, Атланта дахь Шинэчлэгдсэн Теологийн семинарын Системт болон Түүхэн теологийн профессор.

Рев. Др. Симон Виберт бол Англи, Виржиниа Воте дахь Христийн Чуулганы туслах пастор бөгөөд Оксфорд, Вайклифе Холл дахь Номлолын Сургуулийн Дэд Ерөнхийлөгч ба Захирал асан.

Др. Стефен Ж. Вэллум бол Өмнөд Баптист теологийн сургуулийн Христэч теологийн профессор.

ҮГСИЙН ТАЙЛБАР

Адонай – Еврей хэлний “Эзэн”, “Багш”, “Захирагч” гэсэн утгатай Бурханы нэр

Төгс хүчит – “Бүх хүч чадал” гэсэн үгийн тэмдэг нэр. Уламжлалт теологийн нэр томъёонд Бурханы агуу хүч чадал гэдэг нь Түүний “бүхнийг чадагч” буюу “омнипотенс” гэдэг санааг илтгэдэг. Омни гэдэг нь “бүх”, “потенси” гэдэг нь “хүч чадал” гэсэн утгатай

Бурхангүй үзэл (атеизм)– Бурхан байхгүй гэдэг итгэл үнэмшил

Эл Элион – Библи дэх “Хамгийн дээд Бурхан” гэсэн утгатай Бурханы нэр.

Эл Шаддай – Библи дэх “Төгс хүчит Бурхан” гэсэн утгатай Бурханы нэр

Эл/Элохим – “Бурхан” гэсэн утгатай Еврей үг

Экс нихило – “Оргүй хоосноос” гэсэн утгатай Латин хэлц.

Хенотейзм – Олон бурхан байдаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг ч нэг л бурханд өөрсдийгөө зориулдаг итгэл үнэмшил

Моногенес – “нэг ба цор ганц” гэсэн Грек үг (галиглал). Ихэвчлэн “цор ганц бүтээгдсэн” гэж орчуулагддаг

Монотейзм – Цорын ганц Бурханд итгэх итгэл

Мөн чанар – Хэн нэгний үндсэн шинж чанар эсвэл аливаа оршихуйн гол төлөв байдал

Омнипотенс – Төгс хүчит ба хязгааргүй хүч чадал

политейзм – Олон бурханд итгэх итгэл

нэгдмэл/Бурханы нэгдмэл чанар – Бурханы мөн чанар нь олон өөр хэсгээс бүрдээгүй, харин нэгэн бүхэл цул, нэгдэл юм гэсэн утгатай теологийн нэр томъёо

Бурханы цор ганц чанар – Бурхан бол цорын ганц үнэн Бурхан гэдгийг тодорхойлдог теологийн нэр томъёо

Теос – “Бурхан” гэдэг Грек үг (галиглал)

Ялгаагүй нэгэн цул бурхан– Бурхан бол хуваагдашгүй ганц оршихуй бөгөөд бодгалиуд нь хоорондоо ямар ч ялгаагүй гэдэг итгэл үнэмшлийн техникийн нэр томъёо

Иаве – “Би бол Би байгаа” гэдэг хэлцээс гаралтай Бурханы Еврей нэр. Энэ нь ихэвчлэн “ЭЗЭН” гэж орчуулагддаг